



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Бэсүд
Баасанжав ОТГОЛЖИН

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН
СУУРЬ ГЭМТ ХЭРГИЙГ ТОДОРХОЙЛОХ



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн бакалаврын
Зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан:
Л. Хаш /Ph.D/

Улаанбаатар. 2026 он



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

Бэсүд
Баасанжав ОТГОЛЖИН

МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН
СУУРЬ ГЭМТ ХЭРГИЙГ ТОДОРХОЙЛОХ

В Мэргэжлийн индекс
042101

Эрх Зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл

Удирдагч: Л. Хаш /Ph.D/

Шүүмжлэгч: Д. Бэлгүүн /Ph.D/

Улаанбаатар 2026 он

ГАРЧГИЙН ТОВЪЁОГ

МЭДЭГДЭЛ	i
ТАЛАРХАЛ	ii
ТОВЧ ХУРААНГУЙ	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	vi
ОРШИЛ.....	1
Сэдэв сонгосон үндэслэл	1
Сэдвийн тулгамдсан асуудлууд	1
Судалгааны ажлын зорилго.....	1
Судалгааны ажлын зорилтууд	2
Судлагдсан байдлын судалгаа	2
Судалгааны арга зүй	4
I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ	6
1.1. Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт	6
1.2. Мөнгө угаах гэмт хэргийн талаарх онолууд	8
1.3. Хууль зүйн зүйлчлэл болон хууль зүйн үндэслэл	12
1.4. Олон улсын хууль тогтоомж.....	19
II БҮЛЭГ. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ	22
2.1. Мөнгө угаах гэмт хэргийн өнөөгийн байдал	22
2.2. Мөнгө угаах гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдал.....	24
2.3. ФАТФ-ын зөвлөмж	34
2.4. ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх	38
ДҮГНЭЛТ	43
САНАЛ.....	45

НОМ ЗҮЙ	46
---------------	----

МЭДЭГДЭЛ

Санхүү Эдийн Засгийн Их сургуулийн төгсөх курсын оюутан Б.Отголжин нь Эрх зүйн бакалаврын зэрэг горилсон энэхүү судалгааны ажлыг өөрийн бүтээл мөн болохыг баталж байна. Энэхүү бүтээл нь тус сургуулийн оюуны өмч болох бөгөөд дипломын төслийг номын сангаар дамжуулан нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Нэр: Баасанжав овогтой Отголжин

Гарын үсэг:

Огноо: 2026.06.11

ТАЛАРХАЛ

Энэхүү дипломын ажлыг хийж гүйцэтгэх хугацаанд үнэтэй зөвлөгөө өгч, эрдэм мэдлэг, туршлагаасаа харамгүй хуваалцан, судалгааны ажлыг минь бүх талаар чиглүүлэн дэмжиж ямар ч үед тус дэм болдог удирдагч багш Л.Хаш /Ph.D/ багшдаа чин сэтгэлийн гүн талархал илэрхийлье.

Мөн биднийг мэдлэг боловсролтой, ёс зүйтэй, чадварлаг мэргэжилтэн болгон төлөвшүүлэхийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажилладаг тэнхимийн нийт багш, хамт олондоо талархъя.

Эцэст нь бүхий л цаг үед үргэлж итгэж, дэмжин тусалж, түшиг тулгуур болсон гэр бүлийнхэндээ чин сэтгэлийн гүн талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Энэхүү дипломын ажилд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуульд хэрхэн тодорхойлж байгааг ФАТФ-ын Зөвлөмж 3 болон Олон улсын конвенцтэй харьцуулж, хэрэгжилтийн тулгамдсан асуудлыг тодруулахыг зорьсон. Монгол Улс нь "саарал жагсаалт"-д орсноор олон улсын конвенц, гэрээнд нэгдэж мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг өргөн хүрээнд тодорхойлсноор ФАТФ-ын заавал тусгах ёстой 21 суурь гэмт хэрэг болон бусад олон улсын стандартад нийцүүлж Эрүүгийн хуульд бүрэн хамруулж зүйлчилсэн. Гэсэн хэдий ч хар тамхи, авлига, хүн худалдаалах зэрэг өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдэд тавих эрсдэлд суурилсан хяналт шалгалт хангалтгүй байгаагаас үүдэн шүүхийн практикт эдгээр гэмт хэрэгтэй холбоотой мөнгө угаах хэрэг тун цөөн шийдвэрлэгдэж байгаа нь манай улсын мөнгө угаахтай тэмцэх тогтолцооны бодит эрсдэл болж байна гэдгийг шүүхийн шийдвэр, статистик үзүүлэлт, дүн шинжилгээгээр тогтоосон. Эцэст нь суурь гэмт хэргийг илүү нарийвчлан тодорхойлж, практикт хууль, эрх зүйн нэгдмэл ойлголттой болгох, өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдэд тавих хяналт шалгалтыг эрчимжүүлэх чиглэлд санал зөвлөмж дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: *мөнгө угаах, мөнгө угаах гэмт хэрэг, суурь гэмт хэрэг, ФАТФ, саарал жагсаалт, зүйлчлэл, олон улсын конвенц,*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 1. Судлагдсан байдлын судалгаа	2
Хүснэгт 1. 2. Эрүүгийн хууль дахь мөнгө угаах гэмт хэргийн харьцуулалт	16
Хүснэгт 2. 3. Нийт бүртгэгдсэн хэргийн мөнгө угаах гэмт хэргийн эзлэх хувь	22
Хүснэгт 2. 4. Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын мөнгө угаах гэмт хэргийг шалгасан тайлан	22
Хүснэгт 2. 6. 2021-2025 оны Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр	28
Хүснэгт 2. 7. Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхийн шийдвэр	30
Хүснэгт 2. 8. Заавал тусгах суурь гэмт хэрэг болон Эрүүгийн хуульд тусгагдсан	36

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Мөнгө угаах гэмт хэргийн үе шат	7
Зураг 2. 2. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргээр шалгагдсан гэмт хэргийн үзүүлэлт	23
Зураг 2. 3. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2021 он	24
Зураг 2. 4. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2022 он	25
Зураг 2. 5. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2023 он	26
Зураг 2. 6. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2024 он	27
Зураг 2. 7. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2025 он	27
Зураг 2. 8. 2021-2025 оны Давж заалдах шатны хэвээр үлдсэн болон хэрэгсэхгүй болсон шүүхийн шийдвэр	29
Зураг 2. 9. 2012-2015 оны УЕПГ-аас битүүмжилсэн хөрөнгийн хэмжээ болон суурь гэмт хэрэг	40

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлбар
ФАТФ	Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага /Financial action task force/
UNODC	НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газар /United Nations Office on Drugs and Crime/
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МУ	Мөнгө угаах
СГТ	Сэжигтэй гүйлгээний тайлан
ХСБ	Хууль сахиулах байгууллага
APG /Asia	Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх байгууллага Pacific Group on Money Laundering/
AML /CFT Anti-	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх / Money Laundering, Countering the Financing of Terrorism/

ОРШИЛ

Сэдэв сонгосон үндэслэл

Мөнгө угаах гэмт хэрэг нь шууд хохирогчгүй шинжтэй байдаг онцлогтой бөгөөд эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцаанд хамгийн их сөрөг нөлөө үзүүлдэг гэмт хэргийн нэг юм. Иймд ФАТФ-аас улс орнуудад өгсөн зөвлөмжийн дагуу Монгол Улс мөнгө угаах, терроризмын санхүүжүүлэхийн эсрэг тэмцэх системээ боловсронгуй болгох үүрэг хүлээсэн бөгөөд үүний дагуу манай улс Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 18.6.1 18.6.2.1-р зүйлд тусгаж өгсөн.

Энэхүү сэдвийг судлан мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт ямар гэмт хэргүүдийг хамааруулан авч үздэг талаар, Монгол улсын Эрүүгийн хуульд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай эсэх, одоогийн мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд тодорхойлсон гэмт хэргүүдэд ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн хүрээнд заавал тусгах шаардлагатай гэмт хэргүүд багтсан эсэхийг тодорхойлох нь зүйтэй гэж үзэн энэхүү сэдвийг сонгосон.

Сэдвийн тулгамдсан асуудлууд

Монгол Улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотойгоор жил бүр анхан шатны, давж заалдах шатны болон хяналтын шатны шүүхээс нийтдээ ойролцоогоор 70 орчим шийдвэр гардаг байна. Эдгээрийн дийлэнх нь мөнгө угаах гэмт хэргийг дангаар нь бус, бусад төрлийн гэмт хэрэгтэй хавсран үйлдсэн хэрэгтэй холбоотой байдаг. Шүүхээс ийм төрлийн хэргүүдийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт тооцон шийдвэрлэх тохиолдол түгээмэл ажиглагддаг. Эрүүгийн хуульд “гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого” гэсэн ойлголтыг тусгай ангид заасан бүх гэмт хэрэгт хамаарахаар өргөн хүрээнд тодорхойлсон нь мөнгө угаах гэмт хэргийг зөв зүйлчлэх, бодитой шийдвэрлэхэд тодорхой хүндрэл үүсгэж байна гэж үзэж байна. Иймээс ФАТФ-ын зөвлөмж, олон улсын гэрээ, конвенц болон холбогдох хууль тогтоомжийн үзэл баримтлалд тулгуурлан мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн хүрээ, шалгуурыг Монгол Улсын эрх зүйн тогтолцооны хүрээнд илүү нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Судалгааны ажлын зорилго

ФАТФ буюу Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт улс орнуудын заавал тусгах шаардлагатай гэмт хэргүүд Монгол улсын хууль тогтоожид тусгагдсан эсэх, Монгол улсын хууль тогтоомжид мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг

нарийвчлан тусгах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тодорхойлох нь судалгааны ажлын үндсэн зорилго болно.

Судалгааны ажлын зорилтууд

- Мөнгө угаах гэмт хэргийн тухай судлах
- Мөнгө угаах үе шат, арга, хэлбэрүүдийг судлах
- Монгол улсын хууль тогтоомж болон бусад орны хууль тогтоомжид мөнгө угаах гэмт хэргийг хэрхэн тодорхойлсныг судлах
- Мөнгө угаах гэмт хэргийн өнөөгийн статистик судалж, сүүлийн 5 жилийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх
- ФАТФ буюу Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллагаас гаргасан зөвлөмжийг судалж, Монгол улсын Эрүүгийн хуультай харьцуулж дүгнэх

Судлагдсан байдлын судалгаа

Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлохын тулд үүнтэй холбоотой дараах ном, гарын авлага, судалгааны ажил, танилцуулга, ярилцлага, тайлан зэргийг судалсан болно. Үүнд:

Хүснэгт 1. 1. Судлагдсан байдлын судалгаа

№	Судалгааны эх сурвалж	Үндсэн агуулга
1	<i>М. Амина, Г. Мягмарцэрэн (2023) “Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн практик дахь хууль хэрэглээний тулгамдаж буй асуудал ба эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь”</i>	Энэ судалгааны ажлаар мөнгө угаах угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг хуульчлах аргачлалын талаар Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хант Улс, Америкийн Нэгдсэн Улс болон Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсан.
2	<i>МУИС IV түвшний оюутан Х. Мичидмаа, П. Анарзаяа (2023) “ Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн ойлголт, олон улсын туршилага”</i>	Англо Саксоны эрх зүйн тогтолцоотой улсууд болон Эх-Газрын эрх зүйн тогтолцоотой зарим улс орнуудыг харьцуулан, дүгнэж саналаа хүргүүлсэн.

3	<i>Н. Жавхлан, Г. Отгонжаргал (2023) “Мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт ба шийдвэрлэлтэд тулгамдаж буй асуудлууд” Эрдэм шинжилгээний ажил</i>	Энэхүү судалгааны ажлаар мөнгө угаах эрх зүйн зохицуулалтын талаар өмнөх онууд болон одоогийн нөхцөл байдлыг судлан дүн шинжилгээ хийсэн.
4	<i>Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар С. Галбадрах, Д.Дуламсүрэн “Мөнгө угаах гэмт хэрэг” гарын авлага, 2020 он, Улаанбаатар</i>	Мөнгө угаах гэмт хэргийн үүсэл, мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх арга зам болон гадаадын зарим улсуудын жишээ, кейсийг судалж харьцуулж дүгнэсэн.
5	<i>Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн “Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тогтоох аргачлал, ял оногдуулах асуудал” илтгэлийн хураангуй 2024 он</i>	Тус илтгэлд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тогтоох аргачлал, нотлох баримтын үнэлгээ болон ял оногдуулах эрх зүйн асуудлуудыг тайлбарласан.
6	<i>УПЕГ-ЫН сургалт судалгааны төвийн хяналтын прокурор, доктор Б. Өнөрмаа “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт” 2017 он</i>	Монгол Улсад мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн зохицуулалт, олон улсын стандартын хэрэгжилт болон хууль хэрэглээний асуудлыг авч үзсэн.
7	<i>Санхүүгийн зохицуулах хороо “Мөнгө угаах гэмт хэрэг” танилцуулга, 2015 он</i>	Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, үе шат, эрсдэл болон санхүүгийн байгууллагуудын үүргийг танилцуулсан.
8	<i>А.Анударь “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо тулгамдаж буй асуудлууд” бакалаврын зэрэг горилсон дипломны ажил, 2018 он</i>	ФАТФ болон Монгол Улсын хяналтын тогтолцоонд тулгарч буй асуудлуудыг судалсан.
9	<i>Ц. Мөнхдэлгэр “Мөнгө угаах гэмт хэргийн харьцуулсан судалгаа” бакалаврын зэрэг горилсон дипломны ажил, 2023 он</i>	Монгол улсын эрх зүйн тогтолцоог зарим гадаад улсын эрх зүйн тогтолцоотой харьцуулж дүн шинжилгээ хийсэн.
11	<i>Э.Азжаяа “Мөнгө угаах гэмт хэргийн зүйчлэлийн асуудлууд” 2025 он</i>	Саарал жагсаалтыг судалж, гадаадын зарим улс орны эрх зүйн тогтолцоотой харьцуулж дүн шинжилгээ хийсэн.

12	<i>Г. Билгүүжин “Эрүүгийн эрх зүй дэх мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал” 2016 он</i>	Мөнгө угаах гэмт хэргийн олон улсын эрх зүйн зохицуулалт, улс орнуудын туршлага, хөгжлийн чиг хандлагыг харьцуулан шинжилсэн.
13	<i>С.Болортуяа “Мөнгө угаах гэмт хэргийн харьцуулалт, олон улсын практик, чиг хандлага” 2016 он</i>	Монгол Улс олон улсын стандарт, шилдэг туршлагыг нэвтрүүлж, эрх зүйн орчноо сайжруулах шаардлагатай гэж дүгнэсэн.

Судалгааны арга зүй

¹Судалгааны ажлыг хийхдээ судалгааны нийтлэг аргуудаас дараах аргуудыг ашиглана:

- **Анализын арга** – Нэгдмэл үзэгдэл, үйл явцыг бүрэлдэхүүн хэсгүүдэд нь задлан шинжилж, тэдгээрийн онцлог шинж болон харилцан хамаарлыг тодорхойлоход чиглэдэг танин мэдэхүйн арга юм. Энэхүү аргыг судалгааны ажлын онолын болон практик шинжилгээний хэсэгт ашиглана.
- **Синтезийн арга** – Тус тусад нь судалсан мэдээлэл, дүгнэлтүүдийг нэгтгэн уялдуулах замаар нэгдсэн ойлголт, ерөнхий дүгнэлт гаргахад хэрэглэгддэг арга юм. Иймээс энэхүү аргыг дипломын ажлын дүгнэлт болон санал, зөвлөмж боловсруулах хэсэгт ашигланаб
- **Индукц ба дедукцийн арга** – Тусгай тохиолдол, баримт мэдээлэлд үндэслэн ерөнхий дүгнэлт гаргах, эсхүл ерөнхий онол, зарчимд тулгуурлан тодорхой нөхцөл байдлыг тайлбарлах танин мэдэхүйн арга юм. Энэхүү аргыг судалгааны ажлын онолын үндэслэл боловсруулах, судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийх болон нэгдсэн дүгнэлт гаргахад хэрэглэнэ.
- **Харьцуулалтын арга** – Үзэгдэл, үйл явдал, эрх зүйн зохицуулалтыг хооронд нь харьцуулан судалж, тэдгээрийн ижил болон ялгаатай шинжийг тодорхойлох арга юм. Уг аргын хүрээнд зарим гадаад улсын эрүүгийн хууль тогтоомж дахь мөнгө угаах гэмт хэргийн зохицуулалт, шүүхийн практик болон кейсүүдийг Монгол Улсын нөхцөл байдалтай харьцуулан судална.
- **Түүхчлэх арга** – Судлагдаж буй асуудлыг цаг хугацааны хөгжлийн дараалал, өнгөрсөн, одоо болон ирээдүйн уялдаа холбоонд нь авч үзэн шинжлэх арга юм. Энэхүү аргыг мөнгө угаах гэмт хэргийн ойлголт, эрх зүйн зохицуулалтын

¹ Түвдэнжамцийн Сэнгэдорж, Судалгааны арга зүй ном, (Улаанбаатар 2021), 93 дахь тал

хөгжил, Монгол Улсад хуульчлагдсан түүхэн үйл явц болон судлагдсан байдлыг судлахад ашиглана.

Судалгааны шинэлэг тал

Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн талаар нэгдсэн нэг ойлголттой болох мөн мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийг оновчтой тодорхойлох зайлшгүй шаардлага байгаатай уялдан энэ чиглэлийн судалгаанд хувь нэмэр оруулах юм.

I БҮЛЭГ. ОНОЛЫН ХЭСЭГ

1.1. Мөнгө угаах гэмт хэргийн ойлголт

Илт хууль бус эх үүсвэртэй хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж олж авах, шилжүүлэх, хувиргах, эсхүл түүний хууль бус гарал үүслийг нуун далдлах, халхавчлах, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг өөр этгээдэд шилжүүлэх, мөн тухайн хөрөнгийн бодит шинж чанар, хэлбэр, байршлыг өөрчлөх үйлдлийг мөнгө угаах гэж тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэж олсон мөнгө, хөрөнгө болон бусад эдийн засгийн үр өгөөжийг хууль ёсны эх үүсвэртэй мэт харагдуулах, түүний хууль бус гарал үүслийг нуун халхавчлах замаар эргэлтэд оруулах үйл ажиллагааг мөнгө угаах гэж үздэг. “Анх мөнгө угаах арга нь энгийн байсан бөгөөд гэмт хэрэгтэн Аль Капонегийн хууль бусаар олсон мөнгөө хууль ёсны болгох үүднээс Чикаго хотын хими цэвэрлэгээ, угаалгын газруудыг ашигладаг байсан учир ийм төрлийн хууль бус ажиллагааг “Мөнгө угаах” буюу “Money Laundering” гэж нэрлэх болсон”.²

Мөнгө угаах гэмт хэрэг нь тодорхой биет хохирогчгүй байдгаараа онцлог бөгөөд эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцаанд өргөн хүрээний сөрөг нөлөө үзүүлдэг аюултай гэмт хэрэгт тооцогддог. Түүнчлэн энэхүү гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шууд болон бодитоор хэмжих боломж хязгаарлагдмал байдаг тул хор уршиг нь ихэвчлэн шууд бус хэлбэрээр илэрдэг онцлогтой.

Мөнгө угаах үйлдлийг тусгайлан эрүүгийн гэмт хэрэг болгон тооцон хуульчилснаар гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлого, ашиг шимийг хураан авах эрх зүйн үндэс бүрдсэн. Мөн энэхүү зохицуулалт нь зөвхөн гэмт этгээдийг хариуцлагад татахаас гадна гэмт хэргийн орлогыг нуун далдлах, хууль ёсны мэт харагдуулах, түүнчлэн ийм үйл ажиллагаанд санхүүгийн үйлчилгээ үзүүлэх замаар оролцож буй хувь хүн, хуулийн этгээд, санхүүгийн байгууллагуудын хууль бус үйл ажиллагааг таслан зогсооход чиглэгдэж байна.

Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй түгээмэл аргаас дурдвал:

- Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах
- Криптовалютаар шилжүүлэх
- Хандив, тусламж өгөх

² “МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ”, 2019, <https://www.mongolbank.mn/file/files/documents/financialliteracy/publications/23.pdf> (Сүүлд үзсэн: 2026.03.21)

- Хавала, хунди зэрэг хууль бус сүлжээ ашиглах
- Хууль бусаар улс дамжиж бараа тээвэрлэх
- Хувийн мэдээлэл хулгайлж мөнгө дээрэмдэх зэрэг ордог.³

Зураг 1.1 Мөнгө угаах гэмт хэргийн үе шат



Эх сурвалж: <https://www.sankhuuginbolovsrol.mn/>

Мөнгө угаах гэмт хэргийг дараах үе шатанд хуваагддаг. Үүнд:

1. **“Байршуулах үе шат /Placement/:** Энэ үе шатанд их хэмжээний бэлэн мөнгийг хадгалах нь өндөр эрсдэлтэй тул тухайн мөнгийг анхны эх үүсвэрээс нь салгаж, өөр хэлбэрээр байршуулдаг. Зарим тохиолдолд эх үүсвэрийг нь нуун далдлах эсхүл буруу тайлбарлах замаар эргэлтэд оруулдаг. Үүний дараа гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгийг санхүүгийн байгууллага, казино, худалдааны байгууллага, валют арилжааны цэг, түүнчлэн дотоод болон гадаадын бизнесийн байгууллагуудаар дамжуулан санхүүгийн эргэлтэд оруулна.

Тухайлбал: валютын арилжаа хийх, валют дамлан худалдах, үнэт цаасны брокерийн үйл ажиллагааг ашиглах, мөнгөн хэрэгслийг холих, хөрөнгө худалдан авах зэрэг олон төрлийн арга замыг ашигладаг.

2. **“Нуун далдлах үе шат /Layering/:** Энэ үе шатанд хөрөнгийг олон давхар гүйлгээнд оруулж, санхүүгийн системийн хүрээнд дахин дахин шилжүүлэх замаар түүний гарал үүслийг нуун далдлах, илрүүлэхэд хүндрэлтэй болгох

³ С. Галбадрах, Д.Дуламсүрэн, *Мөнгө угаах гэмт хэрэг гарын авлага*, Улаанбаатар 2020, 21 дэх тал

ажиллагааг явуулдаг. Ингэснээр хууль сахиулах байгууллагууд тухайн хөрөнгө болон гэмт хэргийн хоорондын холбоог тогтоох боломжийг хязгаарлах зорилготой байдаг.

Тухайлбал: бэлэн мөнгийг санхүүгийн хэрэгсэлд хувиргах, бизнес худалдан авах, өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүн авах, хуурамч байгууллагын нэрээр цалин олгох, мөн хөрөнгийг хэд хэдэн улс дамжуулан шилжүүлэх зэргээр анхны эх үүсвэрээс нь улам бүр холдуулдаг.

3. **“Буцаан төвлөрүүлэх үе шат /Integration/:** Энэ үе шатанд нэмэлт санхүүгийн гүйлгээ хийж, хөрөнгийг хууль ёсны эх үүсвэртэй мэт харагдуулах зорилготойгоор эдийн засгийн эргэлтэд дахин оруулдаг. Энэ нь хөрөнгийн гарал үүслийг илрүүлэхэд хүндрэл учруулах нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд улмаар тухайн хөрөнгө хууль ёсны орлого мэт харагдах боломжтой болдог.

Ингэснээр гарал үүсэл нь тодорхойгүй болсон эсхүл хууль ёсны мэт харагдах болсон хөрөнгийг гэмт этгээд өөрийн нэр дээр буцаан төвлөрүүлж, чөлөөтэй ашиглах боломж бүрддэг.

Хэсгийн дүгнэлт:

Мөнгө угаах гэмт хэрэг нь гэмт хэргийн замаар олсон орлогын хууль бус эх үүсвэрийг нууж, хууль ёсны мэт харагдуулах үйл ажиллагааг хэлнэ. Энэхүү гэмт хэрэг нь байршуулах, нуун далдлах, буцаан төвлөрүүлэх гэсэн үе шаттай хэрэгждэг бөгөөд эдийн засаг, нийгэмд ноцтой сөрөг нөлөө үзүүлдэг тул олон улсын хэмжээнд чухалчлан авч үздэг гэмт хэрэг юм.

1.2. Мөнгө угаах гэмт хэргийн талаарх онолууд

Цагаан захтны гэмт хэргийн онол

Онолын үзэл санаа: “Криминологич Edwin H. Sutherland 1939 онд “white collar crime” буюу цагаан захтны онолын үндсийг тавьсан. Түүний тодорхойлсноор цагаан захтны гэмт хэрэг гэдэг нь өндөр нийгмийн статус бүхий хүмүүс мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд үйлддэг эдийн засгийн гэмт хэрэг юм. Сазерлендийн судалгаагаар корпорац, банк, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнууд хууль зөрчих

тохиолдол олон байдаг боловч эдгээрийг уламжлалт гэмт хэрэг шиг анхаарч судалдаггүй байсан.”⁴

Энэхүү онолын үүднээс мөнгө угаах гэмт хэрэг нь ихэвчлэн банк санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сан, үл хөдлөх хөрөнгийн зах зээл зэрэг хууль ёсны эдийн засгийн бүтэц ашиглан үйлдэгддэг. Өөрөөр хэлбэл гэмт этгээдүүд хууль бус орлого олж дараа нь түүнийгээ банкны системээр дамжуулан “хууль ёсны” мэт харагдуулдаг. Иймээс мөнгө угаах гэмт хэрэг нь эдийн засгийн гэмт хэрэг, албан тушаал, бизнесийн орчин, санхүүгийн байгууллагад ихэвчлэн үйлдэгддэг гэх шинжээрээ цагаан захтны гэмт хэргийн сонгодог хэлбэр гэж судлаачид үздэг.

Рациональ сонголтын онол

Онолын үзэл санаа: ”Рациональ сонголтын онолын дагуу гэмт хэрэг үйлдэгч этгээд нь үйл ажиллагааныхаа ашиг, эрсдэлийг тооцоолж, харьцуулан үнэлж рациональ буюу бодлоготой шийдвэр гаргадаг байна. Энэ онолын гол агуулга нь гэмт хэрэг нь тохиолдлын шинжтэй бус харин ашиг ба эрсдэлийн тооцоолол дээр үндэслэсэн шийдвэр юм. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтэн гэмт хэргээс олох ашиг, гэмт хэрэг нь баригдах магадлал, шийтгэлийн хэмжээ зэргийг харьцуулж тооцоолж үзээд үйлддэг.”⁵

Онолын үүднээс мөнгө угаах гэмт хэрэг нь:

Судлаачдын тайлбарлаж байгаагаар мөнгө угаах гэмт хэрэг нь рациональ буюу урьдчилан төлөвлөж, нарийн тооцоолол хийж үйлддэг гэмт хэргүүдийн түгээмэл жишээний нэг юм. Учир нь мөнгө угаах ажиллагаа нь банк санхүүгийн байгууллагыг ашиглах, аль улсад компани байгуулах, хөрөнгийг хэрхэн хуваан шилжүүлэх, ямар хөрөнгө оруулалт ашиглах зэрэг олон шийдвэрт үндэслэн гэмт хэргийг үйлддэг.

Эдгээр шийдвэрийг гэмт этгээдүүд баригдах эрсдэлийг багасгах, ашиг хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор гаргадаг. Судалгаагаар мөнгө угаах гэмт хэрэгт оролцогчид нь хууль сахиулах байгууллагын хяналт, санхүүгийн шалгалт, олон улсын мөнгөний урсгал зэргийг судалж хамгийн аюул багатай схемийг сонгодог гэж үздэг. Тиймээс мөнгө угаах гэмт хэрэг нь ашиг эрсдэлийн тооцоолол, санхүүгийн стратеги, нарийн төлөвлөлт дээр үндэслэн гэмт хэрэг гэж тайлбарладаг.

⁴ Sutherland, E. , Encyclopedia of Criminological Theory: Sutherland, Edwin , White-Collar Crime, (SAGE Publications, Inc, 2010), 4-5 . https://study.sagepub.com/system/files/Sutherland%2C_Edwin_H._-White-Collar_Crime.pdf (Сүүлд үзсэн: 2026.03.25)

⁵ By Ayesh Perera, Rational Choice Theory of Criminology, October 5, 2025, <https://www.simplypsychology.org/routine-activities-theory.html> (Сүүлд үзсэн:2026.04.18)

Нийгмийн дарамтын онол

Онолын үзэл санаа: “Нийгмийн дарамтын онолыг анх Америкийн социологич Robert K. Merton 1938 онд боловсруулж “Social Structure and Anomie” нэртэй судалгааны ажилдаа танилцуулсан байна. Мертоны үзэл баримтлалаар аливаа нийгэм тодорхой соёлын үнэт зүйл болон тэдгээрт хүрэх хууль ёсны арга замыг тогтоодог. Тухайлбал орчин үеийн нийгэмд эдийн засгийн амжилт, хөрөнгө чинээ, нийгмийн статус, материаллаг сайн сайхан байдал зэрэг нь хүмүүсийн хүрэх ёстой зорилго гэж тооцогддог.

Мертоны онол нь анх гудамжны гэмт хэрэгтэй холбон тайлбарлагдаж байсан боловч орчин үеийн криминологийн судалгаанд эдийн засгийн гэмт хэрэг, цагаан захтны гэмт хэрэг, санхүүгийн шинжтэй гэмт үйлдлийг тайлбарлахад өргөн хэрэглэгддэг байна.⁶ Мертоны үзсэнээр нийгэмд тогтсон зорилго болон тэдгээрт хүрэх боломжийн хооронд үл нийцэл үүсэх үед нийгмийн дарамт бий болдог. Тухайлбал: Хүн амжилттай баян болохыг хүсдэг, харин боловсрол, эдийн засгийн боломж нь хүрэлцэхгүй байх тохиолдол бий. Ийм нөхцөлд зарим хүмүүс зорилгодоо хүрэхийн тулд хууль бус арга хэрэглэх магадлал нэмэгддэг байна.

Онолын үүднээс мөнгө угаах гэмт хэрэг нь:

Энэ онолын дагуу хүмүүс өөрсдийн зорилго болох эдийн засгийн амжилтад хүрэхийн тулд хууль бус арга ашиглах тохиолдол гардаг. Үүний үр дүнд олон төрлийн гэмт хэргүүд гардаг. Тухайлбал: Авлига, залилан, хууль бус бизнес, хар тамхины худалдаа, татвараас зайлсхийх гэх мэт.

“Эдгээр гэмт үйлдэл нь их хэмжээний хууль бус орлогыг бий болгодог. Тус онолын хүрээнд мөнгө угаах гэмт хэрэг логик дарааллаар үүсдэг байна. Тухайлбал нийгэм хүмүүсээс эдийн засгийн амжилт шаарддаг харин зарим хүмүүс хууль ёсны аргаар тус зорилгодоо хүрэхэд бэрхшээлтэй байдаг. Тиймээс хууль бус аргаар хөрөнгө олж эхэлдэг бөгөөд дараа нь тэрхүү орлогоо ашиглахын тулд мөнгө угаах үйл ажиллагаа явуулдаг.”⁷

Иймээс мөнгө угаах гэмт хэрэг нь нийгмийн дарамтаас үүдэн гарсан эдийн засгийн гэмт хэргийн үргэлжлэл гэж криминологийн судалгаанд тайлбарлагддаг байна.

⁶ Robert Merton, 1938, Social Structure and Anomie. American Sociological Review, Oct., 1938, pp. 672-682. <https://www.csun.edu/~snk1966/Robert%20K%20Merton%20-%20Social%20Structure%20and%20Anomie%20Original%201938%20Version.pdf> (Сүүлд үзсэн:2026.04.18)

⁷ Akers, R., & Sellers, Criminological Theories: Introduction and Evaluation. Oxford University Press, C. 2013, https://dn710001.ca.archive.org/0/items/akers-et-al-2016-1/Akers%20et%20al%202016%20%281%29_text.pdf , (Сүүлд үзсэн:2026.04.19)

Тоглоомын онол

Онолын үзэл санаа: Тоглоомын онол нь хүмүүс болон байгууллагууд хоорондоо стратегийн шийдвэр гаргах тохиолдолд ямар үйлдэл хийдгийг тайлбарладаг математик эдийн засгийн онол юм. Тоглоомын онолын хүрээнд оролцогч бүр өөрийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор стратеги үйлдэл гаргадаг бөгөөд бусад оролцогчдын үйлдлийг урьдчилан тооцоолохыг оролддог байна.

Тоглоомын оролцогчид нь шийдвэр гаргагч талууд болдог. Үүнд: хувь хүн, байгууллага, төрийн байгууллага, гэмт бүлэглэл зэрэг олон оролцож болно. Мөнгө угаах гэмт хэргийн хувьд оролцогчид нь: гэмт этгээд, банк, санхүүгийн байгууллага, хууль сахиулах байгууллага байж болно.⁸

Тоглоомын онолын дагуу мөнгө угаах гэмт хэрэг нь:

Криминологи болон эдийн засгийн судалгаанд тоглоомын онолыг гэмт хэрэгтнүүд болон хууль сахиулах байгууллагын стратегийн харилцааг тайлбарлахад ашигладаг. Учир нь тоглоомын онол нь мөнгө угаах гэмт хэргийг стратегийн харилцаа бүхий үйл явц гэж тайлбарладаг. Гэмт этгээдүүд мөнгө угаах эсэхээ баригдах магадлал болон ашигтай харьцуулж тооцоолдог бол төрийн байгууллагууд илрүүлэх стратеги боловсруулдаг. Мөн улс орнуудын хууль тогтоомж өөр байх нь мөнгө угаагчдад ашигтай тоглогч сонгож үйл ажиллагаа төвлөрүүлэх шалтгаан болдог.⁹ Иймээс мөнгө угаах гэмт хэрэг нь гэмт этгээд болон хууль сахиулах байгууллагын стратегийн харилцан үйлчлэлийн үр дүнд үүсдэг гэж тайлбарладаг.

Үүний үр дүнд мөнгө угаахын эсрэг олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай болдог. Тоглогчдын зан байдал, шийдвэрийг урьдчилан таамаглах ашигтай, эрсдэл, зардал, ашиг хосолсон орчныг судалж, гэмт хэрэгтний стратегийг ойлгоход тусалдаг.

Хэсгийн дүгнэлт:

Мөнгө угаах гэмт хэрэг нь эдийн засгийн, зохион байгуулалттай, олон шат дамжлагатай тул түүнийг зөвхөн хууль зүйн хүрээнд бус онолын үүднээс судлах шаардлагатай. Мөнгө угаах гэмт хэргийг онолын үүднээс тайлбарлах нь уг үзэгдлийг зөвхөн хууль зүйн зөрчил бус, харин нийгэм эдийн засаг, зан төлөв, стратегийн шийдвэр

⁸ Osborne, M. (2004). An Introduction to Game Theory. Oxford University Press, This version: 2000/11/06 https://mathematicalolympiads.wordpress.com/wp-content/uploads/2012/08/martin_j-osborne-an_introduction_to_game_theory-oxford_university_press_usa2003.pdf, (Сүүлд үзсэн:2026.03.21)

⁹ Reuter, P., & Truman, E. 2004, Chasing Dirty Money, https://www.piie.com/publications/chapters_preview/381/1iie3705.pdf , (Сүүлд үзсэн:2026.03.22)

гаргалт зэргийг ойлгоход чухал ач холбогдолтой. Криминологийн судалгаанд онолын хандлага нь гэмт хэрэг үйлдэх шалтгаан, механизм, оролцогчдын зан төлөвийг системтэй тайлбарлах боломжийг олгож, урьдчилан сэргийлэх болон илрүүлэх бодлогыг илүү оновчтой боловсруулахад суурь болдог бөгөөд дан ганц эрдэм шинжлгээний ажил бус эрх зүйн бодлого боловсруулах, хууль хэрэглэх болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд практик ач холбогдолтой. Дээрх онолын хүрээнд үзвэл мөнгө угаах гэмт хэрэг нь өндөр зохион байгуулалттай, зорилготой үйлддэг болох нь харагдаж байна.

1.3. Хууль зүйн зүйлчлэл болон хууль зүйн үндэслэл

Зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд нь санхүүгийн чадавхаа нэмэгдүүлэх зорилгоор бусад улсын гэмт хэргийн сүлжээнүүдтэй холбоо тогтоож, зохион байгуулалттай бүтэц бүрдүүлэн хууль бус зэвсгийн наймаа, түүх, соёлын үнэт олдворын хулгай болон хууль бус худалдаа, дээрэм, хүний эд эрхтний наймаа, хүн худалдаалах, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлт зэрэг олон төрлийн гэмт үйл ажиллагааг эрхэлж, их хэмжээний хууль бус орлого олдог. Ийнхүү амар хялбар аргаар өндөр хэмжээний ашиг олох замаар олсон орлогоо цаашид санхүүгийн эргэлтэд оруулж, мөнгө угаах үйл ажиллагааг өргөн хүрээнд явуулах болсон байна.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд дээрх төрлийн гэмт үйлдлүүдийн үр дүнд бий болсон “бохир” хөрөнгө, орлогыг хууль ёсны эх үүсвэртэй мэт харагдуулах зорилгоор эдийн засгийн эргэлтэд оруулж, санхүүгийн системээр дамжуулан халхавчлан ашигладаг. Өөрөөр хэлбэл, гэмт этгээдүүд хууль бус үйл ажиллагааны үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглах, захиран зарцуулах явцдаа түүний гарал үүслийг нуун далдлах, улмаар хууль ёсны орлого мэт харагдуулахыг үндсэн зорилгоо болгодог байна.¹⁰

Иймд мөнгө угаах гэмт хэрэг нь гол төлөв үндэстэн дамнасан шинжтэйгээр үйлдэгддэг тул уг гэмт хэргийг эсэргүүцэх, түүнтэй тэмцэх, таслан зогсооход улс орнуудын хамтын ажиллагаа чухал бөгөөд нэгдсэн нэг эрх зүйн зохицуулалт, болон уг үйл ажиллагааг зохицуулсан хууль эрх зүйн орчин зайлшгүй шаардлагатай болсон бөгөөд олон улсын гэрээ, конвенцоос гадна улс орон бүр өөрсдийн эрх зүйн системд тохируулан мөнгө угаах гэмт хэргийг хуульчлах нь зүйтэй юм. Монгол улс мөнгө угаах гэмт хэргийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль 2013 он, Эрүүгийн хууль 2015 он болон олон улсын гэрээ конвенцоор зохицуулж байна. Үүнээс гадна

¹⁰ Бауржаны Досжан “Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг харьцуулан судлах нь” *эрдэм шинжилгээний өгүүлэл*, 2018 он 1 дэх тал

Монгол банк болон холбогдох байгууллагуудаас баталсан журмуудаар мөн зохицуулдаг. Үүнийг дэлгэрэнгүй авч үзвэл:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

Монгол Улсын Их Хурлаас анх 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийг баталсан бөгөөд 2 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Хамгийн сүүлд шинэчилсэн найруулгыг 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн. Тус хуулиар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг авах арга хэмжээ, гэмт үйлдлийг мэдээлэх, хяналт шалгалт хийх үүрэгтэй этгээдүүд болон тусгайлан хянах гүйлгээ, сэжигтэй гүйгээ, мэдээллийн нууцыг хадгалах, улсын хилээр бэлэн мөнгө оруулах, гаргах, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага зэргийг хуульчилж өгсөн байдаг.

Хуулийн 3.1.1 дэх хэсэгт ¹¹“Мөнгө угаах гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ” гэж харин “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж, Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 2-т заасныг” ойлгохоор тодорхойлсон байна.

Эрүүгийн хуульд тусгагдсан байдал

Монгол улс мөнгө угаах гэмт хэргийг хамгийн анх 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Эрүүгийн хуульд зүйлчилж байсан. Үүнээс цааш хэд хэдэн удаа уг гэмт хэргийн шинжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

¹²166 дугаар зүйл Мөнгө угаах

166.1.Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол

¹¹ Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013), 3 дугаар зүйлийн 3.1.1

¹²Эрүүгийн хууль 2002, 166 дугаар зүйлийн 166.1.1 166.1.2 166.1.3-р хэсэг

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр зүйлчилсэн.

Харин хүндрүүлэх нөхцөлөөр 166.1.2.Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Мөн 166.1.3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2008 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд

Мөнгө угаах гэмт хэргийг ¹³268¹.1.Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах, эсхүл хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэх зорилготой илт хууль бус эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж эх үүсвэрийг нь халхавчлах буюу нуун далдлах, эсхүл уг эд хөрөнгийг хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж тодорхойлсон бол,

Хүндрүүлэх нөхцөлөөр 268¹.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

268¹.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан байна.

2009 оны Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд

2008 оны мөнгө угаах гэмт хэргийн нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцож доор дурдсан агуулгатайгаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

¹³ ЭХ-ийн 2008, 268 дугаар зүйлийн 268.1-хэсэг

¹⁴166¹.1.Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад / Татвар төлөхөөс зайлсхийх / хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, хувиргасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж заасан бөгөөд 2008 оны заалтаас ихээхэн өөрчилсөн байна.

166¹.2.Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

166¹.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж тус тус тодорхойлжээ.

Харин 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс одоо хүртэл мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын тусгай ангид мөнгө угаах гэмт хэргийг дараах байдлаар зүйлчилсэн.

18.6 дугаар зүйл.Мөнгө угаах

¹⁵18.6.1.Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэж зүйлчилсэн бол,

Хүндрүүлэх нөхцөлөөр 2.Энэ гэмт хэргийг:

2.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;

¹⁴ ЭХ-ийн 2009, 166 дугаар зүйл

¹⁵ ЭХ-ийн 2015, 18 дугаар зүйлийн 18.6

2.2.байнга тогтвортой үйлдэж;

2.3.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2015 оны шинэчилсэн Эрүүгийн хуулиар мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг болох “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэдгийг Ерөнхий ангийн 7.5.2 дугаар зүйлд “Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно” гэж тодорхойлсон байна.

Он оны Эрүүгийн хуульд тусгасан зүйлчлэл нь өөрийн гэсэн онцлогтой, утга агуулгын хувьд хувьсан өөрчлөгдөж ирсэн байна. Эдгээрийг харьцуулж үзвэл:

Хүснэгт 1. 2. Эрүүгийн хууль дахь мөнгө угаах гэмт хэргийн харьцуулалт

	Эрүүгийн хууль 2002 он	Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2008 он	Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2009 он	Эрүүгийн хууль 2015 он
Ялын хэмжээ	хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50-100 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 1-6 сар хүртэл хугацаагаар	хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5 хүртэл	хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51-250 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 5 жил хүртэл	6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулах

	баривчлах, эсхүл 5 хүртэл хугацаагаар хорих оногдуулах	хугацаагаар хорих ял оногдуулах	хугацаагаар хорих ял оногдуулах	
Хүндрүүлэх нөхцөл	онц их хэмжээний хохирол учирсан, албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол гэж	давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол гэж	давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол гэж	тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж; байнга тогтвортой үйлдэж; албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол гэж
Суурь гэмт хэргийн тухайд	...Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого... гэж заасан.	...Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах, эсхүл хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэх зорилготой илт хууль бус эд хөрөнгө... гэж зааасан.	...Хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад / Татвар төлөхөөс зайлсхийх / хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг... гэж заасан	...Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого... Дээрх гэмт хэрэг гэдэгт “...Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар

				заасан гэмт хэрэг...” гэж заасан
--	--	--	--	----------------------------------

Эх сурвалж: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем <https://legalinfo.mn/mn/detail/11634>

Дээрх онуудад хийсэн нэмэлт өөрчлөлт нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг, ялын хэмжээ, хүндрүүлэх нөхцөл зэргийг өөрчилж, зарим хэсгийн хүчингүй болгож зарим хэсгийн нэмэлтээр оруулсан боловч мөнгө угаах гэмт хэргийн ерөнхий агуулга буюу объектив болон субъектив талд томоохон өөрчлөлтийг хийгээгүй байна.

Мөнгө угаах гэмт хэргийн **объектив шинжийг** тодорхойлбол, түүний объект нь банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн эрх зүйн болон санхүүгийн харилцаа юм. Харин объектив тал нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж түүнийг олж авах, эзэмших, ашиглах, мөн түүний хууль бус гарал үүслийг нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчлөх, шилжүүлэх, түүнчлэн тухайн хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах хэлбэр, өмчлөгч болон эд хөрөнгийн эрхийг халхавчлах үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрдэг байна.

Субъектын хувьд Эрүүгийн хуульд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол Улсын иргэн, гадаадын иргэн болон харьяалалгүй хэн ч байж болно. Мөн субъектив тал нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж түүнийг олж авах, эзэмших, ашиглах хэлбэрээр илэрч буй шууд санаатай гэм буруугийн хэлбэр байх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгыг агуулдаг байна.¹⁶”

Хэсгийн дүгнэлт:

Дээрхээс дүгнэхэд мөнгө угаах гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагаатай нягт уялдаатай, ихэвчлэн үндэстэн дамнасан шинжтэйгээр үйлдэгддэг бөгөөд хууль бус эх үүсвэртэй хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулахад чиглэгдсэн онцлогтой байна. Монгол Улсын хувьд энэхүү гэмт хэргийг тусгай хуулиар болон Эрүүгийн хуулиар үе шаттайгаар зохицуулж ирсэн бөгөөд 2002 оноос хойшхи өөрчлөлтүүд нь суурь гэмт хэрэг, ялын хэмжээ, хүндрүүлэх нөхцөл зэргийг

¹⁶ Ц. Мөнхдэлгэр, “Мөнгө угаах гэмт хэргийн харьцуулсан судалгаа”, бакалаврын зэрэг горилсон диплом, СЭЗИС бүтээлийн сан, 2023, 7,8 дахь тал

сайжруулах чиглэлд байсан бол мөнгө угаах гэмт хэргийн субъектив, объектив шинжийг өөрчлөхгүйгээр хадгалсаар ирсэн байна.

1.4. Олон улсын хууль тогтоомж

НҮБ-аас баталсан мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд дараах гурван конвенцыг олон улсын хэмжээнд эрх зүйн гол эх сурвалж болгон ашигладаг байна. Үүнд:

- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг” Венийн конвенц, 1988 он
- “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг” Палермогийн конвенц, 2000 он
- “Авлигын эсрэг” НҮБ-ын конвенц, 2003 он

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц

1988 оны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын конвенц (Венийн конвенц гэж олон улсад нэрлэдэг) нь олон улсын эрх зүйд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх суурийг тавьсан хамгийн анхны бөгөөд ихээхэн чухал баримт бичгийн нэг юм. Тус конвенц нь нэгдэж орсон гишүүн улсуудаас хар тамхины наймаанаас олсон хууль бус орлогын жинхэнэ эх үүсвэрийг нуун дарагдуулах, өөрчлөх, эсвэл хууль ёсны мэт харагдуулах аливаа үйлдлийг өөрсдийн дотоодын хууль тогтоомжид тусгай гэмт хэрэг гэж зүйлчлэхийг зөвлөсөн. Энэхүү конвенцоор мөнгө угаах ойлголтыг зөвхөн хар тамхитай холбон авч үзсэн хэдий ч энэ нь хожим 1989 онд ФАТФ байгуулагдах суурь болсон гэж үздэг байна.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц,

¹⁷НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц нь мөнгө угаах гэмт хэргийг илүү нарийвчлан зүйлчилсэн бөгөөд Венийн конвенцоос ялгаатай нь суурь гэмт хэрэгт хар тамхинаас гадна хүн худалдаалах, эвсгийн наймаа, авлига, мөрийтэй тоглоом зэрэг бүх төрлийн хүнд гэмт хэргүүдийг багтаан заасан явдал юм.

Тус конвенцод мөнгө угаах үйлдлийг гэмт хэргийн орлого гэдгийг нь мэдсээр байж эд хөрөнгийн хууль бус үүсвэрийг нуух, далдлах, эсхүл үндсэн зөрчлийг үйлдэхэд

¹⁷ НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, 2000

оролцсон этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор эд хөрөнгийг өөрчлөх, шилжүүлэх; гэмт хэргийн орлого гэдгийг нь мэдсээр байж эд хөрөнгийн бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, шилжүүлэх, эзэмших буюу бусад эрхийг нуух, далдлах; гэмт хэргийн орлого гэдгийг нь мэдсээр байж эд хөрөнгийг авах, эзэмших, ашиглах үйлдэл” гэж, “гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг” тус конвенцийн 2 дугаар зүйлд “...үл хөдлөх, хөдлөх хөрөнгө, биет эсхүл биет бус бүх төрлийн хөрөнгө хамаарах болон тэдгээр эд хөрөнгийн эрх, ашиг сонирхлыг нотлох хууль зүйн баримт бичиг хэрэгсэл...” гэж тодорхойлжээ. Тодруулбал, мөнгө угаах нь хууль бус орлогыг хууль ёсны мэт харуулахыг зорьдог бөгөөд энэ нь санхүүгийн тогтвортой байдлыг алдагдуулж, эдийн засгийн чөлөөт шударга өрсөлдөөнийг үгүй хийх сөрөг үр дагаврыг дагуулдаг болно.¹⁸ Үүнээс гадна конвенцын 7-р зүйлд энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гишүүн улс орнуудыг санхүүгийн системдээ өндөр хяналт тавихыг үүрэг болгосон.

¹⁹Авлигын эсрэг НҮБ-ын конвенц

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигалын эсрэг НҮБ-ын Конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсан. Авлигал нь бусад гэмт хэрэг, тухайлбал зохион байгуулалттай гэмт хэрэг, мөнгө угаах зэрэг эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотой байдаг тул мөнгө угаах гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх нь зүйтэй гэж үзэн конвенцын 14 дүгээр зүйлд тусгаж өгсөн байна.

Тус конвенцоор мөнгө угаах гэмт хэргийг нарийвчлан зохицуулаагүй ч авлига болон зохион байгуулалттай гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлсон бөгөөд **Суурь гэмт хэрэг** гэж тус конвенцын 23 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргийн зүйл болох орлогыг бий болгосон гэмт хэргийг хэлнэ гэж.

23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт оролцогч гишүүн улсууд санаатайгаар үйлдсэн дараах үйлдлүүдийг гэмт хэрэг гэж тогтооход шаардлагатай бүх арга хэмжээг авна. Үүнд:

- Тухайн эд хөрөнгө нь **гэмт хэргээс олсон орлого** гэдгийг мэдсээр байж хууль бус гарлыг нь нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргах эсхүл суурь гэмт хэрэг

¹⁸ UNITED NATIONS office on Drugs and crime, 2004, https://www.unodc.org/documents/middleeastandnorthafrica/organised-crime/UNITED_NATIONS_CONVENTION_AGAINST_TRANSNATIONAL_ORGANIZED_CRIME_AND_THE_PROTOCOLS_THEREOF.pdf, (Сүүлд үзсэн: 2026.05.05)

¹⁹ Авлигалын эсрэг НҮБ-ын Конвенц, 2003, 23 дугаар зүйл <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760279163531&showType=1>

үйлдсэн аливаа этгээдэд үйлдсэн хэргийнхээ хууль зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор уг эд хөрөнгийг өөрчлөх буюу шилжүүлэх үйлдэл,

- тухайн эд хөрөнгө **нь гэмт хэргээс олсон орлого** гэдгийг мэдсээр байж жинхэнэ мөн чанар болон эх үүсвэр, байршил, захиран зарцуулалт, хөдөлгөөн буюу өмчлөл эсхүл түүн дэх эрхийг нуун дарагдуулах буюу өөрчлөн хувиргах үйлдэл,
- Тухайн эд хөрөнгийг хүлээн авч байх үед **гэмт хэргээс олсон орлого** гэдгийг нь мэдсээр байж худалдан авах, эзэмших буюу ашиглах үйлдэлийг хэлнэ.
- Мөн энэ зүйлийн дагуу тогтоосон аливаа гэмт хэрэгт оролцох, холбогдох, түүнийг үйлдэхэд хуйвалдах болон үйлдэхийг завдах, мөн ийм гэмт хэрэг үйлдэхэд туслах, хатгах, дэмжих буюу зөвлөх үйлдэл

2 дахь хэсэгт дээрх гэмт үйлдлүүдийн суурь гэмт хэргийг аль болох өргөн хүрээнд хэрэглэхийг эрэлхийлнэ гэж заасан. Оролцогч гишүүн улс бүр суурь гэмт хэрэгт наад зах нь энэхүү конвенцын дагуу тогтоосон бүх эрүүгийн гэмт хэргийг оруулсан байна, гэж зөвлөсөн байна.

Харин "Гэмт хэргээс олсон орлого" гэдэгт гэмт хэрэг үйлдэх замаар шууд буюу шууд бусаар олсон эсхүл авсан аливаа эд хөрөнгийг хэлнэ гэж заасан байдаг. Монгол улс нь тус конвенцэд нэгдэн орсноор тус конвенцоор хүлээсэн үүргийнхээ дагуу Эрүүгийн хууль болон тусгайлсан хуулиараа суурь гэмт хэргийг өргөн хүрээнд тодорхойлохыг зорьсоор иржээ.

Хэсгийн дүгнэлт:

Монгол улсад мөнгө угаах гэмт хэрэг болон түүний суурь гэмт хэргийг дотоодын хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенцын хүрээнд дээрх байдлаар тодорхойлсон нь харьцангуй өргөн хүрээнд зохицуулсан гэж харагдаж байна. Мөнгө угаах гэмт хэргийг олон улсын гэрээ конвенцоор зохицуулснаар тухайн конвенцод нэгдэн орсон улс бүр үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгт хамтран хамтран ажиллах, мэдээлэл солилцох, нэгдсэн нэг эрх зүйн зохицуулалтыг баримтлах, гэмт хэргийг нээн илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх зэрэг олон асуудлыг шийдвэрлэж, тус конвенцийг дагаж мөрдөх үүрэг хүлээж байдгаараа давуу талтай. Тодруулбал дээрх гэрээ конвенцоор мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүн шинж, хариуцлага, хяналт, оролцогчдын үүрэг, урьдчилан сэргийлэх арга замыг дэлгэрэнгүй тусгасан бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн улс орнууд аль болох өргөн хүрээнд тодорхойлохыг үүрэг болгосон байна.

II БҮЛЭГ. СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

2.1. Мөнгө угаах гэмт хэргийн өнөөгийн байдал

Монгол улсад жил бүр эдийн засгийн гэмт хэрэг нилээдгүй их бүртгэгддэг бөгөөд үүний дотор “Мөнгө угаах” гэмт хэрэг томоохон байр суурийг эзэлдэг болох нь харагдаж байна. 2021 онд бүртгэгдсэн эдийн засгийн гэмт хэргийн 28 нь мөнгө угаах гэмт хэрэг байсан бол 2024 онд 68 болж өссөн нь жил бүр мөнгө угаах гэмт хэргийн тоо өсөж байгаа бөгөөд энэ гэмт хэргийг зайлшгүй анхаарах шаардлагатай нь харагдаж байгаа юм.

Хүснэгт 2. 3. Нийт бүртгэгдсэн хэргийн мөнгө угаах гэмт хэргийн эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, <https://www.1212.mn/mn>

Мөн жил бүр Улсын Ерөнхий прокурорын байгууллагаас бүтэн жилийн хийсэн ажлын тайланг нийтэд нээлттэй байдлаар гаргадаг бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн хэрэг мөрдөлтийн явцыг доор харуулж байна.


Хүснэгт 2. 4. Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын мөнгө угаах гэмт хэргийг шалгасан тайлан

Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он	2025 он
Хяналт тавьсан нийт хэрэг	336	256	262	280
Яллах дүгнэлт үйлдсэн хэрэг, маргаан	147	74	41	56 яллах дүгнэлт үйлдэж 31 хэрэгт мөрдөн байцаалт явуулж байгаа.
Яллагдагчаар татсан этгээд	-	103	50	-
Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ	9.2 тэрбум		325.9 тэрбум хохирол учирч 13.5 тэрбумыг нөхөн төлүүлсэн	-

Эх сурвалж: Монгол улсын Ерөнхий прокурорын газар, <https://mpo.prosecutor.mn/>

Улсын Ерөнхий прокурорын байгууллагаас 2022 онд 336 мөнгө угаах гэмт хэрэгт хяналт тавьж ажилласнаас 147 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, 9.2 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2024 онд 262 мөнгө угаах гэмт хэрэгт хяналт тавьж ажилласнаас 41 хэрэгт яллах дүгнэлт үйлдэж нийт 50 этгээдийг яллагдагчаар татаж, 325.9 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 13.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн буюу 2022 онтой харьцуулахад гэмт хэмт хэргийн тоо буурсан ч мөнгө угааж олсон бохир мөнгө болон, хохирлын хэмжээ нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа юм. Энэ нь мөнгө угаах гэмт хэрэг нь эдийн засгийн хувьд асар их хор хохирол учруулдаг гэмт хэргүүдийн нэг гэдгийг тодорхойлж байна.

Зураг 2. 2. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргээр шалгагдсан гэмт хэргийн үзүүлэлт



Эх сурвалж: Монгол улсын Ерөнхий прокурорын газар, <https://mpo.prosecutor.mn/>

Зураг 2.-д дурдсанчлан 2022 онд 336 мөнгө угаах гэмт хэрэгт хяналт тавьж ажилласан бол үүний 13.3 хувь нь авлига, албан тушаалын гэмт хэрэг, 45.1 хувь нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 13.9 хувь нь Татвар төлөхөөс зайлсхийх болон эдийн засгийн гэмт хэрэг, 1.8 хувь нь хүрээлэн байгаа орчны гэмт хэрэг суурь гэмт хэргээр шалгагдсан буюу эдгээр гэмт хэргийг үйлдэж олсон мөнгийг угаасан гэж шалгагдсан байна. Дээрх хүснэгтээс үзэхэд 2022 оныг 2023, 2024 онтой харьцуулахад авлига албан тушаалын гэмт хэрэг нь огцом өссөн боловч 2025 онд буурсан гэж харагдаж байгаа бөгөөд 2025 онд 2022 оноос 7.2 хувиар илүү их гэмт хэрэг шалгагдсан байна. Энэ нь Монгол улс мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг өргөн хүрээнд

тодорхойлсон бөгөөд статистик үзүүлэлтээс харахад суурь гэмт хэргээр өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг хамгийн их шалгагдсан байна.

Хэсгийн дүгнэлт:


Дээрх тайлангаас үзэхэд цагдаагийн байгууллагад жил бүр мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргээр шалгагдаж байгаа гэмт хэргийн ихэнх хувийг авлига болон албан тушаалын эсрэг гэмт хэрэг, мөн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд энэ нь мөнгө угаанх гэмт хэргийн суурь гэмт хэргийг өргөн хүрээнд тодорхойлсонтой холбоотой юм. Суурь гэмт хэргийг аль болох өргөн хүрээнд тодорхойлсноор цаашлаад прокурорын газраар шалгагдаж буй суурь гэмт хэргийн илрүүлэх хувь өсөж байгаа нь үүгээр харагдаж байна.

2.2. Мөнгө угаах гэмт хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн байдал

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр

2021-2025 оны Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн ихэнх хувь нь ямарваа нэгэн гэмт үйлдэлтэй болон өөр гэмт этгээдтэй хамтран үйлдсэн байх бөгөөд тэрхүү гэмт үйлдлийг шүүхийн практикт мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг гэж үзэж байна. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн статистик үзүүлэлтийг харьцуулан доор харуулсан байна.

Зураг 2. 3. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2021 он




Эх сурвалж: Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, судлаачийн эмхэтгэл

2021 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой нийт хүчин төгөлдөр 38 шүүхийн шийдвэр байгаа бөгөөд Зураг.2-т

харуулсанчлан мөнгө угаах гэмт хэрэг нь дангаар бус өөр гэмт хэрэгтэй хамтран зүйлчлэгдэн шийдэгдсэн байна. Шүүхийн практикт энэхүү хамтран зүйлчлэгдсэн гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлогыг ашигласан, эзэмшсэн, авсан, эх үүсвэрийг нуун далдалсан зэрэг угаасан үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнд тооцож шийдвэрлэсэн байна. Иймд эдгээр хамтран зүйлчилж буй гэмт хэргийг шүүхийн практикт мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргээр тодорхойлж байгаа юм. Тухайлбал 2021 онд хамгийн их суурь гэмт хэргээр шийдвэрлэгдсэн хэрэг нь Эрүүгийн хуулийн 17.1.1 буюу Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авах, 17.1.2.1. хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч хулгайлах гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө мөнгө орлогыг угаасан хэргүүд байна. Харин хамгийн бага шийдвэрлэгдсэн нь Эрүүгийн хуулийн 17.4.Хөрөнгө завших, 24.6.Хууль бусаар мод бэлтгэх, 28.7. Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших гэмт хэрэг үйлдэн олсон орлогыг угаасан хэргүүд байна.


Зураг 2. 4. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2022 он



Эх сурвалж: Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, судлаачийн эмхэтгэл

2022 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэргийн нийт 62 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Зураг. 4-аас харахад 2022 онд Эрүүгийн хуулийн 17.12.2.1 болон 17.12.2.2-р зүйл Олон тооны малыг бүлэглэж хулгайлах гэмт хэргийг үйлдэж олсон орлогыг угаасан гэмт хэрэг хамгийн их шийдвэрлэгдсэн байна. Харин Эрүүгийн хуулийн 20.3.Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх, 22.1.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 24.3. Химийн


Зураг 2. 6. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2024 он



Эх сурвалж: Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, судлаачийн эмхэтгэл

2024 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой нийт 43 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Үүнээс хамгийн олон давтамжтай, хамтран зүйлчлэгдсэн гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 17.1.1. Хулгайлах, 17.5.1. Алдаатай гүйлгээ, андуурсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө мөнгө, орлогыг угаасан эсхүл эдгээр гэмт хэргээс үүдэлтэй хууль бус мөнгө гэдгийг мэдсээр байж угаасан хэргүүд орж байгаа юм.

Зураг 2. 7. Мөнгө угаах гэмт хэргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр 2025 он



Эх сурвалж: Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, судлаачийн эмхэтгэл

2025 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой нийт 45 хэрэг шийдвэрлэгдсэн бөгөөд 2024 онтой ижил үзүүлэлттэй байгаа юм.

Зураг 3,4,5,6,7-оос үзэхэд мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг нь тодорхой төрлийн гэмт хэрэгт төвлөрч байгаа нь харагдаж байна. Тухайлбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 5 жилийн хугацаанд нийт 252 тохиолдол шийдвэрлэгдсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Энэ нь жил бүр тогтвортой давамгайлж жил бүр буурах хандлагатай байгаа ч бусад төрлийн гэмт хэрэгтэй харьцуулахад өндөр хэвээр байна. Харин эдийн засгийн гэмт хэрэг 5 орчим хувь, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 орчим, авлигын гэмт хэрэг 20 орчим, бусад төрлийн гэмт хэрэг нь харьцангуй бага байгаа нь суурь гэмт хэргийн хүрээнд маш бага хувийг эзэлж байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь нийслэлийн Ерөнхий Прокурорын газраар шалгагдаж буй суурь гэмт хэргийн үзүүлэлттэй адил түвшинд байгаа юм.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021-2025 оны шүүхийн шийдвэрт жилд дунджаар 20-25 мөнгө угаах гэмт хэрэг шийдвэрлэгддэг байна. Мөнгө угаах гэмт хэрэгтэй хамт зүйлчлэгдсэн буюу доор харуулсан гэмт хэргүүдийг үйлдэж олсон орлого, хөрөнгө, мөнгийг угаасан бол мөнгө угаах гэмт хэрэгт тооцож байна.

Хүснэгт 2. 5. 2021-2025 оны Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр

Бүлэг	Зүйл заалт	Мөнгө угаах г.х	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (Хулгайлах, дээрэмдэх, залилах, хөрөнгө завших, алдаатай гүйлгээ андуулсан илгээмж гээгдэл эд хөрөнгө алдуул мал завших, мал хулгайлах...)	17.1.1	18.6.1	3		4		1
	17.1.2.1	18.6.1	4	8	3	3	4
	17.1.3.1	18.6.1	3	1	1		2
	17.2.3.2	18.6.1	2			1	1
	17.2.2	18.6.1	2	1	1	1	2
	17.3.3.1	18.6.2.2	3	1	4	1	3
	17.4.1	18.6.1			1	1	1
	17.12.2.1	18.6.1	1	5	4	2	3
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг	24-р зүйл	18.6.2.2	1			4	
Авлигын гэмт хэрэг	22-р зүйл	18.6.2.3	1	5	3	5	3
Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	20-р зүйл	18.6.2.2				2	2
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	11-р зүйл	18.6.1		1	4	2	1

Эх сурвалж: Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, судлаачийн эмхэтгэл

Монгол Улсын Эрүүгийн хуулиар мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт тусгай ангид заасан бүх төрлийн гэмт хэргийг хамруулахаар өргөн хүрээнд зохицуулсан байдаг. Гэвч 2021–2025 оны шүүхийн шийдвэрийн тоон мэдээллээс үзэхэд мөнгө угаах гэмт хэрэг нь практикт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, тухайлбал “Залилах, хөрөнгө завших, хулгайлах, мал хулгайлах” зэрэг гэмт хэргүүдтэй түлхүү давхар зүйлчлэгдэн шийдвэрлэгдэж байна. Мөн авлигын болон хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй холбоотой цөөн тохиолдол ажиглагдаж байгаа нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг шүүхийн практикт харьцангуй хязгаарлагдмал хүрээнд төвлөрч байгааг харуулж байна.

Зураг2. 8. 2021-2025 оны Давж заалдах шатны хэвээр үлдсэн болон хэрэгсэхгүй болсон шүүхийн шийдвэр



Дээрхээс үзэхэд Давж заалдах шатны шүүхийн магадлалаар ойролцоогоор тал хувь нь мөнгө угаах гэмт хэрэгт холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгох эсхүл мөнгө угаах гэмт хэргийн ялыг хөнгөрүүлэх шийдвэр гаргасан байна. Мөн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүд хоорондоо илт ялгаатай байгаа нь практикт нэгдсэн нэг ойлголттой болох хэрэгцээ шаардлага байгааг илтгэж байна. Тодорхойлбол Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр мөнгө угаах гэмт хэрэг гэж шийдвэрлэгдсэн шийдвэр давж заалдах шатны шүүхээр хэрэгсэхгүй болох тохиолдол олон байгаа нь харагдаж юм.

Эрүүгийн хэргийн Хяналтын шатны шүүхийн шийдвэр

Эрүүгийн хэргийн Хяналтын шатны 2021-2025 оны мөнгө угаах гэмт хэргийн шийдвэр нь ихэвчлэн эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах, залилах, хуурамч баримт бичиг үйлдэх зэрэг ихэнх хувь нь эдийн засгийн гэмт хэргээс үүдэлтэй хөрөнгө мөнгө, орлогыг угаасан гэмт хэргүүд багтаж байна. Эдгээр гэмт хэргийг үйлдэж олсон орлого, хөрөнгийг угаасан хэргээр давхар зүйлчлэгдэх эсхүл эдгээр гэмт хэргээс үүдэлтэй бохир мөнгө болохыг мэдсээр байж угаасан нь суурь гэмт хэргээр зүйлчлэгдэх шалгуур болж байна.

Хүснэгт 2. 6. Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхийн шийдвэр

2021 он	2023 он	2024 он	2025 он
11.6.1 17.1.2.1 17.3.1 18.6.1	22.1.1- 18.6.1	22.4.2 22.5.1 22.10.1 18.6.2.2	268.1 20.3.1 21.10.1 22.4.4 22.5.1 22.5.2 24.2.1 18.6.2.2 18.6.2.3 18.6.3
Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах,	Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах	Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах, хахууль өгөх, үндэслэлгүйгээр хөрөнгөжих	Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших, нийтийн албан тушаалтан хахууль авах, хахууль өгөх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох,
22.12.1 23.2.2 18.6.2.2 18.6.2.3	17.1.2.1 17.12.2.1 17.12.2.2 17.12.2.4 18.6.1		
Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах, хуурамч баримт бичиг үйлдэх	Хулгайлах, мал хулгайлах гэмт хэрэг		
17.3.2.2 18.6.2.2	11.4.1 11.6.1 17.1.1 18.6.1		
Залилах гэмт хэрэг	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах,		
263.2 22.10.1 18.6.2.3	18.6.2.2 22.1.2		
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих ,	Эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах		

Эх сурвалж: Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, судлаачийн эмхэтгэл

Дээрх гэмт хэргүүдээс гадна олон улсын түвшинд мөрийтэй тоглоом, цахим казино, онлайн покер, спорт бооцоо зэрэг нь мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй суурь орчин гэж ФАТФ, APG, UNODC зэрэг байгууллагууд тогтмол анхааруулж ирсэн байдаг. Ялангуяа цахим мөрийтэй тоглоом нь хил дамнасан шинжтэй, их хэмжээний мөнгөн урсгалтай, олон хүнийг хамар ч цахим төлбөр болон криптовалют ашигладаг тул мөнгө угаахад тохиромжтой орчин гэж үздэг.²⁰ Монгол улсын хувьд 2023 оноос эхлэн цахим мөрийтэй тоглоомноос олсон орлогыг бусдын данс, цахим шилжүүлгээр дамжуулан нуун далдалсан үйлдлийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцсон тохиолдол ихээр гарч ирэх болсон ба ФАТФ-ын суурь гэмт хэргийн өргөн хүрээний ойлголттой нийцэж байгаа юм. Иймд шүүхээр шийдвэрлэгдсэн шийдвэрээс жишээ татъя:

Кейс 1. Баянзүрх дүүргийн эрүүгийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 сарын 18-ны өдрийн Дугаар 2023\ШЦТ\1576 шийтгэх тогтоол

Хэргийн талаар: О. Болд нь мөрийтэй тоглоомын газар ажиллуулах зорилгоор үл хөдлөх хөрөнгө түрээсэлж мөн цахим хэрэгсэл ашиглан иргэдэд “Play.mglgame.net” нэртэй “покер” мөрийтэй тоглоом тоглуулж, 2020 оны 05 дугаар сараас 2020 оны 10 дугаар сар хүртэл хаягт үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог “покер” гэх нэртэй мөрийтэй тоглоом зохион байгуулж, мөн 2020 оны 05 дугаар сараас 2020 оны 10 дугаар сар хүртэлх хугацаанд гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж хувьдаа ашиглан мөнгө угаах гэмт хэргийг үйлдэж нийт 45,030,000 төгрөгийн хохирол учруулсан.

Шүүхийн шийдвэр: Шүүгдэгч О.Болдыг үргэлжилсэн үйлдлээр хэд хэдэн гэмт хэргийг буюу мэдээллийн технологи ашиглан ашиг хонжоо олох зорилгоор үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан, мөн гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого буюу мөрийтэй тоглоом зохион байгуулж олсон хууль бус орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, хууль бус эх үүсвэрийг нь нуун далдалж өөр этгээдийн дансанд байршуулсан буюу мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн” гэм буруутайд тус тус

²⁰Vulnerabilities of Casinos and Gaming Sector

<https://www.fatgafi.org/en/publications/Methodsandtrends/Vulnerabilitiesofcasinosandgamingsector.html?>

(Сүүлд үзсэн: 2026. 05.17)

Энэхүү шүүхийн шийдвэр нь мөнгө угаах гэмт хэрэг нь суурь гэмт хэрэгтэйгээ шууд уялдаа холбоотой байдаг бөгөөд суурь урьдчилаад үйлдэгдсэн гэмт үйлдэл байж гэмээ мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгддэг болохыг тод харуулсан жишээ юм. Тодруулбал, тухайн хэрэгт мөрийтэй тоглоом зохион байгуулах замаар хууль бус орлого бий болгосон нь “суурь гэмт хэрэг” болж байгаа бөгөөд энэ хууль бус орлогоо гэмт хэргийн улмаас олсон болохыг мэдсээр байж ашигласан, эргэлтэд оруулсан үйлдэл нь мөнгө угаах гэмт хэргийн бүрэлдэхүүн болжээ. Иймээс шүүх О.Болдын үйлдлийг зөвхөн мөрийтэй тоглоом зохион байгуулах гэмт хэрэг гэж үзэхээс гадна түүний үр дүнд бий болсон орлогыг далдлан ашигласан хэсгийг мөнгө угаах гэмт хэрэг гэж давхар зүйлчилсэн нь суурь гэмт хэрэг ба мөнгө угаах гэмт хэргийн хоорондын “шалтгаан–үр дагаврын” холбоог баталгаажуулж байна.

Кейс 2. Нийслэлийн Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2020 оны 12 сарын 04-ны Дугаар 2020\ДШМ\1455 магадлал

Хэргийн талаар: О.Ананд нь 2007-2009 оны 10 сарын 28-ны өдөр хүртэл МУ Ерөнхий сайдаар ажиллаж байхдаа “Оюутолгой” ордыг ашиглах зорилгоор гадаад, дотоодын хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах болон яриа хэлэлцээр хийхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Одхүү, сайд А.Даш , Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Г.Цэцэг нарт даалгаж, “Оюутолгой” төслийн хүрээнд “Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед” компаниудтай хөрөнгө оруулалтын гэрээг үзэглэх эрхийг хэд хэдэн Засгийн газрын гишүүдэд олгож, мөн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж ажлын явцад олж авсан мэдээллээ албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхолдоо хөтлөгдөн найз Х. Доржийн Петровис Трейдингш ХХК-ийг Оюутолгой ХХК-тай “Шатах, тослох материал нийлүүлэх тухай” гэрээ байгуулж, гэрээг урт хугацаагаар сунгаж 418.385.173.982,34 төгрөгийн орлого олох боломжийг олгож давуу байдал бий болгосон. Нэмээд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж бусдад бий болгосон давуу байдлаас үүссэн хөрөнгийн эх үүсвэрийг нуун далдлах зорилгоор том охин Б.Зул болон Ч.Дэндэв нарын хамтран эрхэлдэг үл хөдлөх хөрөнгийн бизнесийг үргэлжлүүлэн явуулж байгаа гэх шалтгаанаар 2010 оноос 2014 оны хооронд 4 үл хөдлөх хөрөнгийг нийт 11.643.000 ам.доллараар худалдан авч, улмаар дээрх үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогыг эхнэр У.Хонгороогийн дансаар 2011 оноос 2017 он хүртэлх хугацаанд нийт 3.569.148,56 ам.доллар буюу 5.580.444.637,22 төгрөгийг авч, мөнгө угаасан гэмт хэргийг зохион байгуулсан хэрэгт холбогдсон байна.

Шүүхийн шийдвэр: О.Анандыг ЭХ-ийн тусгай ангийн 22.1.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 18.6.1. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнд тооцож нийтийн албанд томилогдох эрхийг 2 жилээр хасаж, 2 жил 6 сарын хугацаанд хорих ялаар, Х.Доржийг Эх-ийн тусгай ангийн 18.6.1. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнд тооцож 1 жилийн хорих ялаар шийтгэж, С.Б-ээс 5.580.444.000 төгрөгийг, Д-ээс 5.766.040.000 хураан авч улсын орлого болгохоор шийдвэрлэсэн.

Энэхүү давж заалдах шатны шүүхийн магадлал нь мөнгө угаах гэмт хэрэг нь өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэг, ялангуяа авлига болон албан тушаалын гэмт хэрэгтэй хэрхэн уялдаж суурь гэмт хэрэг болж буйн тод харуулсан жишээ юм.

Тухайлбал, О.Анандын үйлдэлд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосон үйлдэл нь Эрүүгийн хуулийн 22.1-д заасан гэмт хэрэг болж байгаа бөгөөд энэ үйлдлийн үр дүнд бий болсон их хэмжээний хөрөнгө, орлого нь мөнгө угаах гэмт хэргийн эх үүсвэр болсон буюу суурь гэмт хэрэг нь болсон байна. Улмаар тухайн хууль бус орлогыг үл хөдлөх хөрөнгө худалдан авах, компанийн дансаар дамжуулах, бусдын нэр дээр төвлөрүүлэх зэрэг хэлбэрээр нуун далдалж, санхүүгийн эргэлтэд оруулсан нь мөнгө угаах гэмт хэргийн шинжийг бүрдүүлсэн.

Энэ хэрэг нь авлига, албан тушаалаа урвуулан ашиглах, татвараас зайлсхийх зэрэг өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдээс үүдэн их хэмжээний хууль бус орлого бий болж, түүнийг далдлан хууль ёсны мэт харагдуулах замаар мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгддэг болохыг харуулж байна. Мөн хохирлын хэмжээ их байгаа нь уг гэмт хэргийн нийгэм, эдийн засагт үзүүлэх хор уршиг өндөр байгааг баталж байна.

Хэсгийн дүгнэлт

Анхан шатны шүүхийн практикт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг үйлдэж олсон хөрөнгө мөнгө, орлогыг угаасан эсхүл эдгээр гэмт хэргийг үйлдэж олсон хуувь бус мөнгө гэдгийг мэдсээр байж угаасан бол мөнгө угаах гэмт хэрэгт хамруулан шийдвэрлэж байгаа нь шүүхийн практикт суурь гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлж байгаа юм. Харин шүүхээр шийдвэрлэгдэж буй суурь гэмт хэрэгт авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг, эдийн засгийн өндөр эрсдэлтэй гэмт хэргүүдийн эзлэх хувь бага байгаа нь тус гэмт хэргүүдийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа харьцангуй сул байж болзошгүйг илтгэж байна.

2.3. ФАТФ-ын зөвлөмж

ФАТФ-ын 40 зөвлөмжийн 3-р зөвлөмжид мөнгө угаах гэмт хэргийг тодорхойлсон бөгөөд “Улс орнууд Венийн болон Палермогийн конвенцийн дагуу мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцвол зохино. Мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг түүний дотор **өргөн хүрээний суурь гэмт хэргийг** хамруулвал зохино” гэж, Зөвлөмж 3-ын тайлбар хэсэгт:

- 1- р хэсэгт: Улс орнууд мөнгө угаахыг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенц (Венийн конвенц) болон НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенц (Палермо конвенц)-ийн дагуу гэмт хэрэгт тооцно гэж зөвлөсөн байна.

2- р хэсэгт улс орнууд мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг хамруулж, өргөн хүрээний суурь гэмт хэргийг хамруулбал зохино. Мөн улс орнууд өөрсдийн хууль тогтоомжид үндэснийхээ онцлогоос хамаарч хэд хэдэн аргуудыг хэрэглэж суурь гэмт хэргийг тодорхойлохоор заасан байна. Үүнд:

- суурь гэмт хэрэгт бүх гэмт үйлдлийг хамруулах
- хүнд гэмт хэргийн ангилалд хамаарах үйлдлийг хамруулах
- суурь гэмт хэрэгт оногдуулах хорих ялаас босго тогтоох,
- суурь гэмт хэргийн жагсаалт гаргах
- дээрх аргуудыг хослуулан холимог аргачлалаар хамруулж болно.²¹

Манай улсын хувьд эдгээр аргачлалаас зарим хэсгийг нь удирдлага болгон Эрүүгийн хуульдаа суурь гэмт хэргийг тодорхойлсон байна. Тухайлбал:

1. **2002 оны Эрүүгийн хууль**- Бүх төрлийн гэмт хэргийг хамааруулах аргачлалыг хэрэглэсэн бөгөөд “Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого...” гэж ерөнхий байдлаар тодорхойлсон.
 2. **2008 оны Нэмэлт өөрчлөлтөөр**- Гэмт хэргийн жагсаалт гаргах аргачлалыг ашигласан бөгөөд “...Зэвсэг, хар тамхи, хүн худалдаалах, эсхүл хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэх зорилготой илт хууль бус үйлдэл...” зэргийг суурь гэмт хэрэгт хамааруулан тодорхойлсон байна.
 3. **2009 оны нэмэлт өөрчлөлтөөр**- Суурь гэмт хэрэгт оногдуулах хорих ялаас (босго тогтоох аргачлал) буюу “Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад / Татвар төлөхөөс зайлсхийх / хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг...” суурь гэмт хэрэг гэж үзсэн.
 4. **2015 оны Эрүүгийн хууль**- Бүх гэмт үйлдлийг хамааруулах аргачлал буюу “Эрүүгийн хуулийн 7.5.2-р зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого гэж Монгол Улсад бол энэ хуулийн тусгай ангид заасан...” гэмт хэргийг суурь гэмт хэргээс тодорхойлсон байна.
- 3- р хэсэгт улс орнууд босго аргачлал хэрэглэсэн бол суурь гэмт хэрэгт тухайн улсынхаа хууль тогтоомжийн дагуу хүнд гэмт хэргийн ангилалд багтдаг бүх гэмт хэргийг хамруулах эсвэл нэг жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэдэг гэмт хэргийг хамруулах мөн гэмт хэргийн хамгийн бага ялыг тогтоодог хууль эрх зүйн тогтолцоо

²¹ Санхүүгийн мэдээллийн алба ТСТ болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, 2020.01.08, 36, 37 дахь тал, <https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/20180531F2.pdf>, (Сүүлд үзсэн: 2026.05.05)

бүхий улс орнуудын хувьд суурь гэмт хэрэг нь зургаан сараас дээш хугацаагаар хорих ялаар шийтгэдэг бүх гэмт хэргийг хамруулбал зохино гэж тусгаж өгсөн байна.

- 4- “р хэсэгт ямар аргачлалыг хэрэглэхээс үл хамааран улс орнууд суурь гэмт хэргийн ангилалд орсон 21 төрлийн гэмт үйлдлийг мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэгт заавал хамруулан зүйлчлэх шаардлагатай “²² гэж заасан байна.

Хүснэгт 2. 7. Заавал тусгах суурь гэмт хэрэг болон Эрүүгийн хуульд тусгагдсан

№	ФАТФ-ын зөвлөмжид тусгасан суурь гэмт хэрэг	Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2015 он
1.	Зохион байгуулалттай гэмт бүлэгт оролцох, дарамтлах	Эрүүгийн хуулийн 20.3.Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх болон 3.8.Зохион байгуулалттай гэмт бүлэг гэж зүйлчилсэн.
2.	Терроризм, терроризмыг санхүүжүүлэх	Эрүүгийн хуулийн 29.10.Терроризмыг санхүүжүүлэх, болон 20.1.Террорист үйлдлийн талаар зориуд хядал мэдээлэх мөн 20.2.Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах гэж
3.	Хүн худалдаалах, цагаачдыг хууль бусаар хил давуулах	Эрүүгийн хуулийн 13.1. Хүн худалдаалах болон 19.14.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх, 19.15.Хууль бусаар иргэний харьяалал олж авах
4.	Бэлгийн мөлжлөг (хүүхдийн бэлгийн мөлжлөгийг оролцуулаад)	Эрүүгийн хуулийн 12.3. Бэлгийн мөлжлөг,
5.	Хар тамхи болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг хууль бусаар худалдах	Эрүүгийн хуулийн 20.7. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, 20.8. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх орон байраар хангах, 20.9. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших, 20.10. Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах
6.	Хууль бус зэвсгийн наймаа	Эрүүгийн хуулийн 20.4. Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших 20.5. Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх
7.	Хулгайн болон бусад бараа бүтээгдэхүүний хууль бус худалдаа	Эрүүгийн хуулийн 25.5. Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах,зуучлах
8.	Авлига, хээл хахууль	Эрүүгийн хуулийн хорин хоёрдугаар бүлэг. Авлигын гэмт хэрэг
9.	Залилан	Эрүүгийн хуулийн 17.3. Залилах гэмт хэрэг
10.	Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх	Эрүүгийн хуулийн 18.7. Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах

²² Санхүүгийн мэдээллийн алба, өмнөх эшлэл 20, 2020.01.08, 129 дэх тал <https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/20180531F2.pdf> (Сүүлд үзсэн: 2026.05.06)

11.	Бараа, бүтээгдэхүүн хуурамчаар үйлдэх болон зохиогчийн эрхийг зөрчих	Эрүүгийн хуулийн 18.17. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих, 18.4.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчийн эрхийг зөрчих
12.	Байгаль орчны эсрэг гэмт хэрэг	Эрүүгийн хуулийн хорин дөрөвдүгээр бүлэг
13.	Хүний амь нас бүрэлгэх, хүнд гэмтэл учруулах	Эрүүгийн хуулийн Аравдугаар бүлэг. Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 11.1. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 11.2. Санаасэтгэл хүчтэй цочрон давчдаж хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулах, 11.3. Хүний эрүүл мэндэд хүнд хохирол болгоомжгүйгээр учруулах
14.	Хүн хулгайлах, хууль бусаар эрхийг нь боогдуулах, барьцаалах	Эрүүгийн хуулийн 13.2. Хүн хулгайлах, 13.3. Хүн барьцаалах, Арван гуравдугаар бүлэг. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг
15.	Хулгай, дээрэм	Эрүүгийн хуулийн 17.1. Хулгайлах, 17.2. Дээрэмдэх
16.	Хууль бусаар хил нэвтрүүлэх (гааль болон нэмүү өртгийн албан татвартай холбоотой асуудал орно)	19.14.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх
17.	Татварын гэмт хэрэг	Эрүүгийн хуулийн 18.7. Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах 18.3. Татвар төлөхөөс зайлсхийх
18.	Айлган сүрдүүлэх	Эрүүгийн хуулийн 13.5.Заналхийлэх
19.	Баримт бичгийг хуурамчаар үйлдэх	Эрүүгийн хуулийн 23.2. Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах,
20.	Далайн дээрэм	
21.	Худалдааны дотоод мэдээлэл ашиглах, үнэт цаасны зах зээлд хууль бус үйлдэл хийх	Эрүүгийн хуулийн 18.8.Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж, арилжаанд оролцох 18.9. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах

Эх сурвалж: ФАТФ-ын зөвлөмж, Эрүүгийн хууль 2015

Улс орнууд дээрх жагсаалтыг суурь гэмт хэрэгт хамруулахдаа гэмт хэргийн төрлөөр нь болон уг гэмт хэргийн бүрэлдэхүүний ямар элемент нь онц ноцтой гэмт хэрэг болгож буйг дотоодын хууль тогтоомжийн дагуу тодорхойлох ёстой бөгөөд Монгол улсын хувьд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүх хүнд, хөнгөн гэмт үйлдлийг хамруулдаг тул дээрх гэмт үйлдлүүдийг суурь гэмт хэрэгт хамруулан тодорхойлсон байна.

5- р хэсэгт Бусад улсад үйлдэгдсэн суурь гэмт хэрэг нь дотоодод үйлдэгдсэн бол суурь гэмт хэрэг гэж тооцогдох байсан нь мөнгө угаахтай холбоотой суурь гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай. Улс орнууд суурь гэмт хэрэгт хамруулах шалгуураар зөвхөн дотоодод үйлдэгдсэн тохиолдолд суурь гэмт хэрэгт тооцогдох байсан бол гэсэн

нөхцөлийг тавьж болохоор заасан. Харин Монгол улсын хувьд ²³Эрүүгийн хуулийн 7.5.2-р зүйлд зааснаар "Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого" гэдгийг Монгол Улсад бол тус хуулийн тусгай ангид заасан бүх гэмт хэрэг, гадаад улсад бол тухайн улсын хуулиар нэг жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэргийг үйлдэж шууд, шууд бусаар олсон эдийн, эдийн бус хөрөнгө, түүний үнэ, түүнээс олсон ашиг, орлого, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно гэж тодорхойлсон буюу гадаад улсад үйлдэгдсэн гэмт хэргийн тухайд босго тогтоож суурь гэмт хэргийг тодорхойлсон байна.

Хэсгийн дүгнэлт

ФАТФ-ын зөвлөмж 3-ын хүрээнд Монгол улс Эрүүгийн хуулиа олон удаа шинэчилж, нэмэлт өөрчлөлтүүдээр суурь гэмт хэргийг улам өргөн хүрээнд тодорхойлж ирсэн байна. Ингэхдээ аль болох ФАТФ-ын зөвлөмж болон олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн тодорхойлохыг зорьж ирсэн байна.

2.4. ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх

Монгол Улс нь 2003 онд “Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц”-д нэгдэн орсноор олон улсын хэмжээнд мөнгө угаахтай тэмцэх эрх зүйн үүрэг хүлээсэн. Үүний дараагаар 2004 оны 06 дугаар сард ФАТФ-ын APG-ийн гишүүн болж, 2012 оны 05 сард Евроазийн бүсийн ажиглагчийн статустай болсноор МУТСТ олон улсын стандартуудыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжоо сайжруулах, олон улсын гэрээ, конвенцтой уялдуулах шаардлагатай болсон. Ингэснээр 2006 онд анх МУТСТ тухай хуулийг батлан гаргасан байна.

ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх аргачлал нь 2012 оны 2 дугаар сард шинээр батлагдсан ФАТФ-ын зөвлөмжид тулгуурлан техникийн хэрэгжилтийг үнэлэх суурь болж тухайн улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг дүгнэхэд ашиглагддаг аргачлал юм.²⁴ 2007 оноос эхлэн манай улс ФАТФ-ын идэвхтэй хяналтад орж 2012 онд тус аргачлалын дагуу үнэлгээ хийхэд 40 шалгуур үзүүлэлтээр “муу” болон “дунд” үнэлгээ авч “хангалтгүй” буюу хууль эрх зүйн зохицуулалт боловсронгуй болоогүй гэж дүгнэгдсэнээр Монгол улс “Саарал жагсаалт”-д орсон. Үүнээс улбаалан

²³ ЭХ-ийн 2025 , 7 дугаар зүйл,

²⁴ Санхүүгийн мэдээллийн алба, ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх аргачлал, 2013.02, <https://frc.mn/resource/frc/images/vote/FATFMethodology%2040.pdf> , (Сүүлд үзсэн: 2026.05.07)

2013 оны 05 сарын 31-ний өдөр УИХ-аас МУТСТ тухай хуулийг олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн шинэчлэн найруулж, үүгээрээ мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг аль болох өргөн хүрээнд тодорхойлж эхэлсэн нь ихээхэн чухал үзүүлэлт болж 2014 оны 06 дугаар сард тус жагсаалтаас албан ёсоор гарсан байна.²⁵

2017 оны харилцан үнэлгээний дэлгэрэнгүй тайланд:

Тус тайлангаар “Монгол Улс олон төрлийн эрсдэл, эмзэг сул талтай нүүр тулж байгааг онцолсон. Тодруулбал өндөр эрсдэлтэй гэмт хэрэгт залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, татвараас зайлсхийх, авлига болон хээл хахууль зэрэг гэмт хэргүүд багтаж байгаа бол дундаж эрсдэлтэй ангилалд хар тамхи, контрабанд буюу хилээр хууль бусаар нэвтрүүлэх, зохион байгуулалттай гэмт хэрэг, банкны зохицуулалтын эсрэг гэмт хэрэг, хулгай мөн гадаадад үйлэгдсэн гэмт хэргийн орлоготой холбоотой хэргүүд хамаарч байна. Мөн суурь гэмт хэргийн улмаас бий болсон орлогыг Монгол Улсад болон гадаад улс орнуудад угаах тохиолдол түгээмэл байгаа бөгөөд прокурорын байгууллага, мөрдөн шалгах албанаас санхүүгийн мэдээллийг ашиглан МУ болон суурь гэмт хэргийн мөрдөн шалгалтыг эхлүүлэх явдал харьцангуй цөөн байна гэж дүгнэсэн. Үүнээс гадна өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл хангалтгүй, банк бус санхүүгийн байгууллагууд СГТ бараг мэдээлэлддэггүй, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид СГТ огт мэдээлдэггүй зэрэг нь эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд ахиц гарахгүй байх шалтгаан болж байна”²⁶ гэж дурдсан.

Түүнчлэн ХСБ болон прокурорын байгууллагуудын үндэсний зорилтуудад хөрөнгө хураах асуудал зохих түвшинд хангалттай тусгагдаагүй хэдий ч ХСБ-ууд суурь гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгийг битүүмжилж, шүүхээс хөрөнгө (тухайлбал, өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотой) хураадаг байна. Гэсэн хэдий ч эдгээр өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотойгоор хураагдсан хөрөнгийн гэмт хэргийн төрлөөр ангилан нарийвчлан гаргасан статистик мэдээлэл хангалтгүй байгааг илэрхийлсэн. Харин тайлангийн С (Эрсдэл өндөр) хэсэгт Монгол улсын өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдийг онцлон авч үзсэн бөгөөд:

²⁵ “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл, 2019, https://www.mongolbank.mn/file/files/documents/MB_sanhuu17-4-108-91-101.pdf, (Сүүлд үзсэн: 2026.05.18)

²⁶ Санхүүгийн мэдээллийн алба, Монгол банкны харилцан үнэлгээний тайлан 2017, 4 дэх тал, <https://fiu.mongolbank.mn/mn/r/78> (Сүүлд үзсэн: 2026.05.06)

Суурь гэмт хэрэгт– Монгол Улсад сүүлийн жилүүдэд эдийн засгийн гэмт хэрэг огцом нэмэгдэж ирсэн бөгөөд үнэлгээний баг дараах 4 төрлийн суурь гэмт хэрэгт анхаарал хандуулав. Үүнд:

- Татвараас зайлсхийх,
- Байгаль орчны журмын эсрэг гэмт хэрэг,
- Авлига ба хээл хахууль (Трансперенси Интернешнл байгууллагаас тооцсон Монгол Улсын авлигын төсөөллийн индекс сүүлийн жилүүдэд сайжирч 2015 онд 168 орноос 72-т орсон)
- Залилан зэрэг орж байгаа юм. УЕПГ-аас 2012-2015 оны хооронд 110 сая ам.долларын хөрөнгө битүүмжилсний дийлэнх нь өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгө байгаа юм.²⁷

Зураг 2. 9. 2012-2015 оны УЕПГ-аас битүүмжилсэн хөрөнгийн хэмжээ болон суурь гэмт хэрэг

Гэмт хэргийн төрөл	УЕПГ-аас битүүмжилсэн хөрөнгө			Анхан шатны шүүхийн шийдвэрээр хураасан хөрөнгө		
	Хэргийн тоо	Сая төгрөг	Сая ам.долл	Хэргийн тоо	Сая төгрөг	Сая ам.долл
Өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүд						
Залилан	598	203,083.8	83.26	681	52,934.80	21.70
Байгаль орчны эсрэг гэмт хэрэг	407	5,182.2	2.12	447	1,559.70	0.64
Татвараас зайлсхийх	23	8,731.5	3.58	18	1,375.00	0.56
Авлига	195	16,078.5	6.59	72	20,918.10	8.58
Бүлгийн дүн	1,223	233,076.0	95.56	1,218	76,787.6	31.48

Дундаж эрсдэлтэй суурь гэмт хэргүүд

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	142	284.2	0.12	167	1.50	0.00
Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, нэвтрэх	159	4,910.1	2.01	179	14,364.30	5.89
Банкны зөрчил	18	80.9	0.03	21	72,658.00	29.79
Хулгай/дээрэм	5139	8,640.3	3.54	5186	15,572.20	6.38
Бүлгийн дүн	5,457	13,915.5	5.71	5,553	102,596.	42.06
МУ	6	7,855.6	3.1	1	19,009.92	7.6
Бусад суурь гэмт хэрэг	860	13,545.2	5.67	1,410	17,475.88	7.36
Бүгд	7,546	268,392.0	110.04	8,182	215,869	87.90

Эх сурвалж: Монгол банкны харилцан үнэлгээний тайлан 2017 он

Үүний үр дүнд 2017 оны үнэлгээгээр Монгол Улс ФАТФ-ын Зөвлөмж 3-ын ихэнх шаардлагыг хангаж биелүүлсэн гэж дүгнэгдсэн бөгөөд энэ нь тодорхой хэмжээнд арга

²⁷ Санхүүгийн мэдээллийн алба, *өмнөх эшлэл 24*, 22 дахь тал, (Сүүлд үзсэн: 2026.05.07)

хэмжээ авч, зарим зөвлөмжийн үнэлгээг ахиулсан боловч бодит үр нөлөө хангалтгүй хэвээр байсан тул 2019 онд албан ёсоор “Саарал жагсаалт”-д орсон. Иймд ФАТФ-аас 2019 онд Монгол Улсад тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөө өгч голлон мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлэх, суурь гэмт хэрэгтэй холбоотой хөрөнгө хураах, битүүмжлэх ажиллагааг сайжруулах мөн терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт, зохицуулалтыг бэхжүүлэх, санхүүгийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагыг сайжруулах зэрэг чиглэлээр үүрэг хүлээлгэсэн бөгөөд үүний дараа Монгол Улс 2019–2020 онд AML/CFT тогтолцоонд өргөн хүрээний шинэчлэл хийсэн. Үүнд:

- ЭХ болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах,
- Санхүүгийн мэдээллийн албаны мэдээлэл боловсруулах чадавхыг нэмэгдүүлэх,
- Цагдаа, прокурор, АТГ, ТЕГ-ийн хамтарсан мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлэх зэрэг олон ажлыг богино хугацаанд хийж ахиц гаргаснаар 2020 оны 10 дугаар сарын 23-нд Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргасан.

ФАТФ Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдлаа хангалттай хэмжээнд арилгасан гэж дүгнэсэн байна. Гэсэн хэдий ч APG болон ФАТФ-ын дараагийн харилцан үнэлгээний тайлангуудад Монгол Улс “эрчимжүүлсэн хяналт”-д хэвээр байгаа бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн бодит мөрдөн шалгалт, хөрөнгө хураалт, суурь гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн сайжруулах шаардлагатай гэж дурдсан байдаг.

2025 оны харилцан үнэлгээний тайлан

Тус тайлангаар дэлгэрэнгүй тайлан гаргаагүй бөгөөд Монгол улс болон Олон улсын хамтын ажиллагааны талаар гүйцэтгэсэн ажлын тайланг нэмэлтээр дурдсан. Үүнд:

- 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улсын хооронд эрүүгийн хэрэгт харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулсан. Энэ нь хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн байна.
- Цагдаагийн ерөнхий газар болон Монголбанк 2024 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр “Хамтын ажиллагааны санамж бичиг” байгуулж, санхүү, эдийн засаг болон эрх зүйн мэдлэгийг олон нийтэд түгээх, хууль тогтоомжийн ойлголтыг нэмэгдүүлэх, залилан болон мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, банкны харилцагч болон хадгаламж эзэмшигчдийн эрх, хууль

ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцсон байна.

- Мөн 2024 онд Монгол Улс ФАТФ-ын Виртуал хөрөнгийн холбоо барих бүлэгт АРГ-ийг төлөөлөгчөөр сонгогдсон нь олон улсын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцож байгааг илэрхийлсэн.

Үүнээс гадна дотооддоо хэрэгжүүлсэн онцлох арга хэмжээний нэг нь Улсын Ерөнхий прокурорын 2024 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/88 дугаар тушаалаар мөрдөгч, прокуроруудаас бүрдсэн ажлын хэсэг байгуулагдсан явдал юм. Энэхүү ажлын хэсэг нь “Мөнгө угаах болон үндэсний эрсдэлийн үнэлгээгээр тодорхойлогдсон өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг мөрдөн шалгах, яллах, хөрөнгө хураах болон зэрэгцээ мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргачлал”-ыг боловсруулж, хэвлэн нийтэлсэн байна.

²⁸ Гэсэн хэдий ч Монгол Улс МУТСТ тогтолцооны үр нөлөөг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ч, үр дүнтэй байдлын шинэчлэл хэсэгт тодорхой мэдээлэл ирүүлээгүй тул АРГ-ийн Хамтын үнэлгээний журмын Х хэсэгт заасны дагуу өргөтгөсөн хяналтын горимд хэвээр үлдэж, цаашид тогтмол тайлагнаж ажиллах үүргийг хүлээлгэсэн.

Хэсгийн дүгнэлт:

Монгол Улс ФАТФ-ын 2017 оны харилцан үнэлгээгээр мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр нөлөө сул, ялангуяа суурь гэмт хэрэг (авлига, татвараас зайлсхийх, залилан, байгаль орчны эсрэг гэмт хэрэг гэх мэт)-ээс үүссэн хууль бус орлогыг илрүүлэх, мөрдөх, хөрөнгө хураах ажиллагаа хангалтгүй байсан тул 2019 онд саарал жагсаалтад орсон. Үүний дараа Монгол Улс ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн дагуу Эрүүгийн хууль болон МУТСТ тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, мөнгө угаах эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгон суурь гэмт хэргийг өргөн хүрээнд тодорхойлж, хууль бус эх үүсвэрээс үүдэлтэй хөрөнгийг хураах ажиллагааг сайжруулсан байна. Үүний үр дүнд Монгол Улс 2020 онд саарал жагсаалтаас гарсан хэдий ч цаашид мөнгө угаах гэмт хэрэг болон суурь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоогоо олон улсын стандартын дагуу тогтвортой сайжруулах шаардлагатай хэвээр байгаа юм.

²⁸ Монгол банк, Монгол банкны харилцан үнэлгээний тайлан 2025, 2 дахь тал <https://fiu.mongolbank.mn/mn/r/2040> (Сүүлд үзсэн: 2026.05.07)

ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тодорхойлох асуудлыг онолын болон практикийн түвшинд судлан, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг олон улсын гэрээ, конвенц болон ФАТФ-ын зөвлөмжтэй харьцуулан дүгнэсэн болно.

Монгол улс 2002 онд мөнгө угаах гэмт хэргийг Эрүүгийн хуульд анх тусгаж, 2006 онд МУТСТ тухай хуулийг батлан гаргасан ч энэ үед суурь гэмт хэргийг нарийн зохицуулаагүй, эрх зүйн тогтолцооны хувьд учир дутагдалтай байсан. Харин “Саарал жагсаалт”-д хоёр удаа орсноор, олон улсын гэрээ конвенц болон ФАТФ-ын зөвлөмжид аль болох нийцүүлэн томъёолохыг зорьсоор ирсэн байна. Харин Одоогийн мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүх гэмт хэргийг хамруулахаар тодорхойлсон нь Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон ФАТФ-ын зөвлөмж 3-д заасан “Мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг түүний дотор өргөн хүрээний суурь гэмт хэргийг хамруулбал зохино гэсний дагуу бүх гэмт хэргийг хамруулах аргачлалын хүрээнд заавал тусгах ёстой 21 гэмт хэргийг хамруулж олон улсын стандартад нийцүүлэн өргөн хүрээнд тодорхойлсон байна.

Мөн 2021–2025 оны Эрүүгийн хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд Монгол улс суурь гэмт хэргийг өргөн хүрээнд тодорхойлсноор мөнгө угаах гэмт хэргийн шийдвэрлэлтийн тоо нэмэгдэж, суурь гэмт хэргээр тогтоогдож буй давхар зүйлчлэгдсэн гэмт хэргийн ангилал ихэссэн байна. Гэсэн хэдий ч эдгээр суурь гэмт хэрэг нь харьцангуй энгийн, ахуйн шинжтэй, хохирол багатай гэмт хэрэг байгаа юм. Харин гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг, эдийн засгийн өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдийн эзлэх хувь бага байгаа нь тус гэмт хэргүүдийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа харьцангуй сул байгааг илтгэж байна.

Үүний зэрэгцээ анхан шат, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрүүд хоорондоо ялгаатай байгаа нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн тодорхойлолт, эрх зүйн орчин, практик хэрэглээ бүрэн нэгдмэл болоогүй гэж тодорхойлогдож байна. Мөн сүүлийн жилүүдэд цахим мөрийтэй тоглоом, цахим гэмт хэрэгтэй холбоотой мөнгө угаах хэргүүд нэмэгдэж байгаа нь мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэрэг улам өргөсөж, шинэ эрсдэл үүсэж байгааг харуулж байна.

Иймд хэдийгээр Монгол улс суурь гэмт хэргийг өргөн хүрээнд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүх гэмт үйлдлийг суурь гэмт хэргээр тодорхойлсон ч өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг илрүүлэх, практикт хуулийг зөв хэрэглэх, нэгдсэн нэг ойлголттой болох, цаашид мөнгө угаах болон, түүний суурь гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна гэж дүгнэж байна.

САНАЛ

Судалгааны дүн шинжилгээ болон дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, практик хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна.

1. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн ойлголт, зүйлчлэлийн нэгдмэл байдлыг хангах зорилгоор Улсын дээд шүүхээс суурь гэмт хэргийг тодорхойлох талаар зөвлөмж, тайлбар гаргах шаардлагатай.
2. Өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэрэгтэй зэрэгцүүлэн мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Улсын ерөнхий прокурорын газраас авлига, татвараас зайлсхийх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг зэрэг өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргүүдэд хамаарах нэгдсэн арга зүйн зааврыг боловсруулан мөрдүүлэх.
3. Сүүлийн жилүүдэд суурь гэмт хэргийн хамрах хүрээ улам өргөсөж байгаа тул хууль сахиулах байгууллагын ажилчдад суурь гэмт хэргийн зүйлчлэл болон энэ төрлийн чиглэлээр тогтмол мэргэшүүлэх сургалт зохион байгуулж урьдчилан сэргийлэх боломжтой.
4. Мөнгө угаах гэмт хэргийн суурь орлогыг нуун далдлахаас өмнө илрүүлж, таслан зогсоохын тулд банк, ББСБ, хуулийн фирм зэрэг мэдээлэх үүрэгтэй этгээдүүд болон Санхүүгийн зохицуулах хороо, УЕП, цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны нэгдсэн сүлжээг бэхжүүлж, гүйлгээний хууль бус эх үүсвэр нь бүрэн нотлогдохгүй ч мөнгө угаах гэмт хэргийн сэжигтэй шинж илэрсэн даруйд цагдаа, прокурорын байгууллагад нэн даруй шилжүүлэн шалгуулдаг мэдээлэл солилцооны шуурхай механизмыг бүрдүүлэх хэрэгтэй.

НОМ ЗҮЙ

1. Эрх зүйн эх сурвалж:

1. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, 2003 он.
2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг Венийн конвенц, 1988 он.
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013 он .
4. “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг” Палермогийн конвенц, 2000 он.
5. Эрүүгийн хууль, 2002 он.
6. Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, 2008 он.
7. Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, 2009 он.
8. Эрүүгийн хууль, 2015 он.

2. Монгол хэл дээрх эх сурвалж:

1. Бауржаны Досжан, *Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг харьцуулан судлах нь*, эрдэм шинжилгээний өгүүлэл, legaldata.mn, 2018 он.
2. Мөнхнарын Амина, Ганбаярын Мягмарцэрэн, *Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийн практик дахь хууль хэрэглээний тулгамдаж буй асуудал ба эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь*, legaldata.mn, 2023 он.
3. Монгол Улсын дээд шүүхийн шүүгч Батдоржийн Батцэрэн, *Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг тогтоох аргачлал, ял оногдуулах асуудал, илтгэлийн хураангуй*, Монгол улсын Дээд шүүх, 2024 он.
4. Сайханбаярын Галбадрах, Дашдоржийн Дуламсүрэн, *Мөнгө угаах гэмт хэрэг гарын авлага*, Улаанбаатар хот, 2020 он.
5. Судалгаа, мэдээлэл, сургалтын төвийн захирал Буяак Айбек /Ph.D/ , *Мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй тэмцэх арга барил, дэлхийн чиг хандлага*, 2022 он.
6. Түвдэнжамцийн Сэнгэдорж, *Судалгааны арга зүй ном*, Улаанбаатар хот, 2021 он.
7. Цолмонгийн Мөнхдэлгэр, *Мөнгө угаах гэмт хэргийн харьцуулсан судалгаа*, бакалаврын зэрэг горилсон диплом, СЭЗИС бүтээлийн сан, 2023 он.

3. Гадаад хэл дээрх эх сурвалж:

А. Англи хэл дээрх эх сурвалж

1. Sutherland, E. , Encyclopedia of Criminological Theory: *White-Collar Crime*, (SAGE Publications, Inc, 2010), 911–916
2. By Ayesha Perera, *Rational Choice Theory of Criminology*, October 5, 2025,
3. Robert Merton, *Social Structure and Anomie*. *American Sociological Review*, Oct., 1938, pp. 672-682.
4. Akers, R., & Sellers, *Criminological Theories: Introduction and Evaluation*. Oxford University Press, C. 2013,
5. Osborne, M. *An Introduction to Game Theory*. Oxford University Press, 2000.11.06, pp.685
6. Reuter, P., & Truman, E, *Chasing Dirty Money*, 2004, pp.8
7. FATF “*Vulnerabilities of Casinos and Gaming Sector*”, 2024

4. Цахим эх сурвалж:

1. Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/97961?daterange=2021-01-01%20-%202025-12-31&id=1&court_cat=2&bb=1
2. Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, https://shuukh.mn/single_case/14345?daterange=2020-01-01%20-%202020-12-21&id=2&court_cat=2&bb=1
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь: <https://www.mongolbank.mn/file/files/documents/financialliteracy/publications/23.pdf>
4. Монгол улсын Ерөнхий прокурорын газар: <https://prosecutor.mn/>
5. Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан: <https://shuukh.mn/cases/2/1>
6. Монгол банк, Монгол банкны харилцан үнэлгээний тайлан 2025: <https://www.mongolbank.mn/mn/r/12243>
7. Санхүүгийн мэдээллийн алба МУТСТ болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт: <https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/20180531F2.pdf>
8. Санхүүгийн мэдээллийн алба, МУТСТ болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт: <https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/20180531F2.pdf>

9. Санхүүгийн мэдээллийн алба, ФАТФ-ын зөвлөмжийн техникийн хэрэгжилт болон МУТСТ тогтолцооны үр дүнтэй байдлыг үнэлэх аргачлал:
<https://frc.mn/resource/frc/images/vote/FATFMethodology%2040.pdf>
10. Санхүүгийн мэдээллийн алба, Монгол банкны харилцан үнэлгээний тайлан 2017: <https://fiu.mongolbank.mn/mn/r/78>
11. Үндэсний статистикийн хороо:
<https://www.1212.mn/mn/statcate/report/Society%2C%20development/Law%20and%20crime>